



“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ

Нийслэлийн Засаг Захиргааны У байр,
А корпус, Бээжингийн гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191-0030
Утас: (976) 7011 8411, 7011 8410
Цахим шуудан: info@ubtheatre.mn
Цахим хуудас: www.ubtheatre.mn

2023.12.27 № 186
танай 2023.12.07 -ны № 03/7462 -т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ**

“Улаанбаатар театр” ОНӨТҮГ нь танай 2023 оны 12 дугаар сарын 07-ны 03/7762 тоот албан бичгийн дагуу 2023 оны Хариуцлагын гэрээний жилийн эцсийн дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.



ДАРГА

Ю.ГЭРЭЛБААТАР

**УЛААНБААТАР ТЕАТРЫН 2023 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**



**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

“УЛААНБААТАР” ТЕАТРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 26


2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Засгийн газрын тогтоол болон НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас дараах ажлуудыг зохион байгуулж ажиллав.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ -1: ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЭЛ, МОНГОЛ ӨВ СОЁЛЫГ СУРТАЛЧИЛСАН СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛНА.

1.1.Урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх замаар, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлсэн байна.

Хэрэгжилт-1: Нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, уран сайхны боловсролыг нь дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, үндэсний уламжлалт соёлыг өвлүүлэн эзэмшүүлэх олон талын ач холбогдлыг дагуулсан “ДЭЛХИЙН МОД” синтез мюзикл жүжиг Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх Улаанбаатар хотын соёл урлагийн мэргэжлийн шинэ бүтээн байгуулалт “БӨМБӨРЦӨГ ТЕАТР”-т 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нээлтээ хийн, 2023 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг дуустал тайзнаа 10 удаа амжилттай тоглож, нийт 3000 гаруй үзэгчдийн хүртээл болсон ба зорилтот бүлгийн 1200 орчим хүүхдүүдэд 2 удаагийн тоглолтонд үнэ төлбөргүй үйлчиллээ.

Улаанбаатар театрын тайз анги болон уран бүтээлчид, циркийн жүжигчид, маркетингийн баг оролцсон нийт 130-аад хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.



Хэрэгжилт-2: 2023 оны 08 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд Хүй долоон худагт болсон “Монголчуудын өв соёлын Даншиг наадам- Хүрээ цам 2023”-д Улаанбаатар театр нь зохион байгуулагч байгууллагаар оролцсон ба нээлтийн үйл ажиллагааны хөтөлбөрийг шинэлэг хэлбэрээр хийж 10.000 гаруй үзэгчдэд толилууллаа. “Бөмбөрцөг театр”-т “Colors of Mongolia” бүрэн хэмжээний тоглолтоо 450 гаруй наадамчин олонд үнэ төлбөргүй амжилттай тоглосон.



Тус наадамд “Улаанбаатар театр” ОНӨТҮГ нь дараах ажлуудыг зохион байгуулж ажиллав. Үүнд:



- Наадмын нээлтийн үйл ажиллагаа
- Төв талбайн тайзны чимэглэл
- Брендбүүк, хэвлэлийн дизайн эх бэлтгэл
- Худалдаа үйлчилгээний талбайд байрлах арк
- Бөмбөрцөг театрт байрлах тайз, дэлгэц
- Төв талбайд байрлах жижиг тайзууд, лед дэлгэц
- Дуу шумны баг
- Бөмбөрцөг театрыг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс нүүлгэн байрлуулах
- Бурхан багшийн дүртэй бутафор чимэглэл зэргийг хариуцан ажиллав.

“Монголчуудын өв соёлын Даншиг наадам – Хүрээ цам” наадмын нээлтийн үйл ажиллагаанд зориулсан Даншиг наадмын түүхэн гарвал, ерөнхий сценари, хөтөлгчийн хэлэх үг зэргийг нэгтгэсэн зохиолыг Төрийн соёрхолт, Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн, Зохиолч Дамбын Төрбатаар бичүүлж, Улаанбаатар театрын нийт уран бүтээлчид, 108 уртын дуучин, 60 уран нугараач, 108 морин хуурч, 60 бүжигчдийг хамруулан Ерөнхий найруулагчаар Улаанбаатар театрын дарга Ю.Гэрэлбаатар, туслах найруулагчаар Улаанбаатар театрын Ерөнхий найруулагч Б.Сүхээ нар ажилласан.





Дээрх ажлуудаас гадна “Монголчуудын өв соёлын Даншиг наадам-Хүрээ цам” наадмаар зохион байгуулагдах Монгол туургатны эрдэмтэн, судлаачдын “Нүүдэлчдийн нийслэл” эрдэм шинжилгээний хурал, Яруу найргийн үдэш, Монгол туургатны уран бүтээлчдийн болон есөн дүүргийн ардын авьяастнуудын шилмэл бүтээлүүд, Улаанбаатар театрын “Colors of Mongolia” тоглолт зэрэг үйл ажиллагаа явагдах Бөмбөрцөг театрыг 2023 оны 07-р сарын 22-ноос 2023 оны 08-р сарын 03-ны өдрийн хооронд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс буулган, Хүй долоо худаг дахь талбайд зөөвөрлөн угсарч, “Монгол туургатан эрдэмтэн судлаач, түүхчдийн өргөө” хэмээн нэрийдэн, “Монголчуудын өв соёлын Даншиг наадам-Хүрээ цам” наадмын өдрүүдэд “Нүүдэлчдийн нийслэл” Олон Улсын эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар театрын “Colors of Mongolia” ардын урлагийн цуврал тоглолтууд, Яруу найргийн үдэш, 9 дүүргийн ардын авьяастнуудын тоглолт зэргийг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Соёл урлагийн газар, Улаанбаатар театр, Хотын төв номын сангийн хамт олон хариуцан зохион байгуулж, наадамчин олонд толилуулж ажилласан.



Хэрэгжилт-3: 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Налайх дүүрэгт зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд “Зүүн Азийн Залуучуудын наадам”-ын шүүгчдэд зориулсан 60-70 хүний хүлээн авалтанд театрын бүжигчид “Журай гэлдэн”, “Уялдах учир” бүжгүүдээ толилуулсан, 08 дугаар сарын 18-ны өдрийн нээлтийн үйл ажиллагаанд Оркестр бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон байна.



Хэрэгжилт-4: 2023 оны 09 дүгээр сард ӨМӨЗО-ны Хөх хотод зохиогдсон “Монгол-Хятадын экспо”-д зориулсан Хятад-Монгол-ОХУ-ын хамтарсан нээлтийн тоглолтонд Улаанбаатар театрын 19 уран бүтээлч ардын урлагаа сурталчлан гадаад, дотоодын үзэгч олонд толилууллаа.



Хэрэгжилт-5: 07 дугаар сарын 27-нд Архангай аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойн нээлтэнд Улаанбаатар театрын уран бүтээлчид зочноор оролцон мэндчилгээ дэвшүүлсэн.



ХОЁРДУГААР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ -2:
 УРЛАГИЙН ОЛОН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ЖИГД ХӨГЖҮҮЛЖ, ИРГЭД, ОЛОН НИЙТ
 БОЛОН ГАДААДЫН ЖУУЛЧДАД СУРТАЛЧИЛАН ТАНИУЛАХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ,
 ҮНДЭСНИЙ АГУУЛГА ШИНГЭСЭН БҮТЭЭЛИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛНЭ.

2.1.Иргэд жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагаа зохион байгуулна.

Хэрэгжилт: НЗДТГ-аас зохион байгуулсан “Амар байна уу” үзэсгэлэнгийн нээлт, “Өвлийн наадам”-ын нээлт, “Их хотын бүсгүйчүүд-2023” арга хэмжээ болон төлөвлөсөн томоохон ажлуудын нэг болох “Дэлхийн мод” синтез жүжгээ 12 удаа тоглож, 3000 гаруй үзэгч олон, хүүхэд багачуудад сонирхууллаа. Мөн НАЖГ-тай хамтран “Морьт харваа”, “Аялал жуулчлалын ITM-2023” үзэсгэлэнгийн нээлт, “Талын салхи” фестивалын нээлтийн үйл ажиллагаануудад давхардсан тоогоор 68 уран бүтээлч оролцон, 2500 орчим үзэгчдэд тоглолтоо үзүүлсэн байна.



2023 оны 9 дүгээр сарын 28,29-ны өдрүүдэд “Улаанбаатар түншлэл-2023” олон улсын үзэсгэлэнгийн нээлтэнд Гоцлол дуучин О.Анхчимэг /МУСТА/, Ц.Гансүх /МУСТА/, Улаанбаатар театрын цөөхүүл хөгжимчид, “Цамын бүжиг”, “Уран сугсраа” бүжгээрээ хурсан олны мэлмийг баясгалаа.



Улаанбаатар театр, Muppet theatre-ын хамтын бүтээл Доктор Сьюзийн "Гринч зул сарыг хулгайлсан нь" дэлхийн шилдэг зохиолоос сэдэвлэсэн "ЗӨРҮҮД ГРИНЧ" зул сарын сахилгагүй драмын жүжгийг 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар театрын тайзнаа нээлтээ хийн 12 удаагийн тоглолтоор нийт 4000 үзэгч, хүүхэд багачууддаа толилуулсан байна.



Улаанбаатар театр
13 November

Доктор Сьюзийн "Гринч зул сарыг хулгайлсан нь" дэлхийн шилдэг зохиолоос сэдэвлэн "ЗӨРҮҮД ГРИНЧ" зул сарын сахилгагүй драмын жүжгийг Улаанбаатар театр, Muppet theatre хамтран бүтээж үзэгч хүүхэд багачууддаа толилуулахад бэлэн боллоо. 🎭🎪🎨
Эрхэм хүндэт үзэгчид, хүүхэд багачууд та бүхнийг хүрэлцэн ирж үзэхийг урьж байна.

📅 2023.12.09, 10 -ны өдрүүдэд
🕒 11:00 | 13:00 | 15:00 цагуудаас
👉 У... Mehr anzeigen



Шинэ жилийн баярыг угтан НЗДТГ, Нийслэлийн Соёл урлагийн газар хамтран "Му УВ-Бид хамтдаа Улаанбаатарыг бүтээнэ" уриан дор "Улаанбаатарын мөнгөн үдэш" арга хэмжээнд 12 дугаар сарын 24,25-нд Улаанбаатар театрын Гоцлол дуучин Д.Шижирмаа, "Авьяаслаг Монголчууд-2023" шоуны финалын оролцогчид Хөгжимчин Г.Бат-Өлзий, Б.Батжаргал, "Авьяаслаг Монголчууд-2016" шоуны финалын оролцогчид Хөгжимчин


Х.Бархүү, Лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэн нар Үндэсний хөгжмийн зэмсгээр дэлхий нийтэд танигдсан алдарт хөгжмийн зохиолчдын бүтээлүүдээс дээжлэн тоглож, эрхэм үзэгчдийн сонорыг мялаасан тоглолт болсон.



ГУРАВДУГААР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ -3:
 ҮНДЭСНИЙ АГУУЛГА БҮХИЙ СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ,
 ХОТЫН СОЁЛЫГ ДЭЭДЭЛСЭН ИРГЭНИЙГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.

3.1. “Хотын соёл” цуврал контент бий болгож, цахим нөлөөллийн аяныг хэрэгжүүлнэ.


Хэрэгжилт: Нийслэлийн Соёл урлагийн газраас хэрэгжүүлж байгаа “Хотын соёл” аянд нэгдэж, цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ-ЫН урлагийн танхимд **“АНХААРАЛТАЙ – МЭДЛЭГТЭЙ – МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙЯ”** хууль эрх зүйн танин мэдэхүйн сургалт зохион байгуулав.



Энэхүү арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, их дээд сургуулийн 1 дүгээр курсийн оюутан залуучууд, Сүхбаатар дүүргийн 8 хорооны иргэд, Улаанбаатар театрын албан хаагчид зэрэг нийт 300 гаруй хүнд дээрх байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, лекц, асуулт хариулт, өнөөгийн нийгэмд тулгамдаж буй гэмт хэрэг зөрчлөөс бидний ирээдүй болсон хүүхэд залуусаа хэрхэн яаж хамгаалах гэдэг тодорхой төрлийн, тэдний үеийнхэнд нэн хэрэгтэй мэдлэг мэдээллээр хангах, мэргэжлийн урлагийн байгууллага нь соёл урлагийн ажлаараа соёлын боловсрол олгох, түүнийг түгээн дэлгэрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай хослуулан хийснээр зорилтот бүлэгт амжилттай хүрч чадсан гэж бид дүгнэж байна.

Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрт: СЭМҮТ-ийн төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, сэтгэл засалч Ж.Гантулга “Архи, мансуурал, дэлгэцийн донтох эмгэг”, Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах зохицуулагч, Цагдаагийн ахмад Д.Ганхуяг “Хүүхэд өртсөн зам тээврийн ослын шалтгаан нөхцөл”, ЦЕГ-ын хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Б.Ариунтөгс “Хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Пүрэвдорж “Залилах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр илтгэл тавьж оролцсон.




Мөн манай арга хэмжээний гол онцлог нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд оролцож дохионы хэлээр сургалт лекц орсноор энэ удаагийн арга хэмжээний маань нэг онцлог юм. Бид энэхүү арга хэмжээг цаашид илүү олон албан байгууллага болон төрийн бус байгууллага хүүхэд залуучуудыг хамруулан арга хэмжээний цар хүрээг томруулах зорилготой байна.



3.2 Нийслэлийн соёл урлагийн салбарын болон Улаанбаатар театрын хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулна.

Хэрэгжилт: Нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллагын хүний нөөцийн нэмэгдүүлэх зорилготой санал дэвшүүлж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/263 дугаар захирамжаар Улаанбаатар театрын бүтэц орон тоог 146 болгон батлуулсан. Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхээр Номадик балет, Анир поп оркестртэй хамтран ажиллах гэрээ хийж, нээлттэй зарласан ажлын байран сонгон шалгаруулалт зарласан. Энэхүү сонгон шалгаруулалтад нийт 76 уран бүтээлч бүртгүүлсэн. 12 дугаар сарын 4,5,6-ны өдрүүдэд сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулсан бөгөөд шүүгчдийн бүрэлдэхүүнд театрын Уран сайхны

зөвлөл ажиллав. 2024 оны 1 сарын 1-нээс эхлэн шинэ бүрэлдэхүүнээр ажиллах уран бүтээлчдийн болон бусад хүний нөөцийн бүрэлдэхүүнийг бүрдүүлж бэлэн болгосон. Мөн 2024 оны 01 дүгээр сарын 11,12,13-ны өдрүүдэд театрын уран бүтээлчдийг сонгон шалгаруулалтад тэнцсэн уран бүтээлчдийн хамт аттестатчилалын шалгалт авахаар төлөвлөөд, бэлтгэл ханган ажиллаж байна. Аттестатчилалын шалгалтад тэнцсэн уран бүтээлчидтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, орон тооны квотыг гүйцээж ажилд авахаар төлөвлөөд байна.



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ -4:

4.1.МУ-ын Засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, “Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай” хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хэрэгжилт: Хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагаанд нийт 21 хууль буюу соёл урлагийн салбартай хамааралтай 3, нийтлэг

мөрддөг 18 хуулийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, тайлант хугацаанд театрын даргын (26)-А тушаал, (71)-Б тушаалыг дээрх хуулийн зүйл заалттай уялдуулан баталж, мөрдөж ажилласан.

4.2.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.


Хэрэгжилт: НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд сарын гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланг хянаж баталгаажуулан нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, холбогдох хууль, журмын дагуу мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2023 оны жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансанд 2023 онд 125 мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэйгээр байршуулж ажилласан.

4.3.Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж, нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, хариуцлагыг өндөрсгөж ажиллана.

Хэрэгжилт: Нийслэлийн Засаг даргын Б/08, Б/09, Б/12, А/111, А/194, А/263, А/717, А/814, А/1069 дүгээр захирамжийн биелэлтийг ханган ажиллаж, хэрэгжилтийн тайланг хагас жил, 3 дугаар улирлын байдлаар, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хагас жилээр гарган НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст, Нийслэлийн Засаг даргын 55 шуурхайн үүрэг даалгаврын биелэлтийг www.ulaanbaatar.mn сайт, ERP чатаар, ХШҮ-нд цаг хугацаанд нь тайлагнаж ажилласан.



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх тухай арга хэмжээний тухай” 02, 03 дугаар албан даалгаврын дагуу 01,11,12-р сард халтиргаа, гулгаа үүссэн газруудыг хусаж цэвэрлэн, иргэдийн аюулгүй зорчих боломжийг бүрдүүлж өгсөн.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг угтан Хан-Уул дүүргийн Айцын аманд 89 мод, Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Баяндөхөмд 103 мод тарьсан бөгөөд энэ 5-р сард тарьсан модны арчилгаа, хаврын усалгааг хийж ажилласан.

Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, ногоон хот, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс иргэн бүр мод тарихыг уриалж байгууллагын сошиал хуудсаар дамжуулан иргэдэд зориулсан постууд хийж ажилласан байна.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Эх дэлхийн цэвэрлэгээний өдөр” удирдамжид заасан хуваарийн дагуу 09 дүгээр сарын 16-ны өдөр “Их тойруу” Гэсэр сүмийн уулзвараас Баянбүрдийн тойрог хүртэл замын 2 талыг Улаанбаатар театрын албан хаагчид хог, шил, ундааны сав, тамхины иш, бутны доорхи, шуудуун доторх хог хаягдлуудыг цэвэрлэж, 20 шуудай хог ачууллаа.

Энэхүү цэвэрлэгээний үр дүнд Гэсэр сүмийн уулзвараас Баянбүрдийн тойрог хүртэлх замын 2 тал хог хаягдалгүй цэвэр орчинтой боллоо.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот – Иргэний оролцоо” намрын мод тарих аяны хүрээнд 10 дугаар сарын 13-ны өдөр “Айц”-ын аманд байрлын театрын нэр бүхий талбайд нэмэлтээр 40ш мод тарьж, өмнөх жилүүдэд тарьсан модны арчилгаа /модны нүхэнд ургасан зэрлэг өвсийг зулгаан, хог хаягдлыг цэвэрлэн, усалгаа хийн/ хийлээ.







4.4. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулна.

Хэрэгжилт: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын албан ёсны цахим хуудас болон албан ёсны Нийслэлийн Улаанбаатар чуулга, Улаанбаатар театр facebook page-ээр дамжуулан соёлын үйл ажиллагааг тухай бүр мэдээллийг шинэчлэн, байгууллагын соёл урлагийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан. Байгууллагын цахим хуудсыг 4 сард шинэчилж ажилд оруулсан ба байгууллагад мөрдөгдөж буй хууль, дүрэм журмыг шинэчлэн байршуулсан байна.

2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар Улаанбаатар театр facebook page-д нийт 103 мэдээ, мэдээлэл оруулж 335.000 хүнд хүрч, 1125 дагагчаар нэмэгдсэн байна.

“Улаанбаатар театр”-ын шинэ уран бүтээл “Дэлхийн мод” синтез жүжгийн зар сурталчилгааг зургаан долоо хоногийн турш Улаанбаатар театр, Улаанбаатар чуулгын пэйж, Serchmaa пэйжүүдээр/ **хандалт 311555** /tseg.mn, zow.mn, tsahiur.mn, zarig.mn сайтуудаар /**хандалт 23871**/, SBN, MNB, HD Mongol /**хандалт 135000**/, Мобиком, Юнителийн **63636** хэрэглэгч нар луу мэдээлэл цацагдсан байна.



Мөн, ХУД-ийн 11-р хороо Зайсангийн гүүрний зүүн хойно, ХУД-ийн 3-р хороо Чөлөө Таван богд ХХК-н төв байр, ХУД-ийн 1-р хороо Олимпийн гудамж Нарны зам дагуу, Баянгол дүүргийн 14-р хороо 3-р хороолол Л.Энэбишийн өргөн чөлөө Түмэн худалдааны төв, Их монгол улсын гудамж дах Лед дэлгэцүүдээр өдөрт 120-200 удаагийн давтамжтайгаар “Дэлхийн мод” уран бүтээлийн болон театрын танилцуулга видео сурталчилгааг байршуулж ажилласан.

Улаанбаатар театр, Muppet theatre-ын хамтын бүтээл Доктор Сьюзийн "Гринч зул сарыг хулгайлсан нь" дэлхийн шилдэг зохиолоос сэдэвлэсэн "ЗӨРҮҮД ГРИНЧ" зул сарын сахилгагүй драмын жүжгийг 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар театрын тайзнаа 12 удаа тоглосон ба тус хүүхдийн жүжгийн зар сурталчилгаа Улаанбаатар театрын пэйж болон Фэйсбүүк пэйжүүдээр явагдаж тасалбарыг Ticket.mn дээр борлуулсан.





4.5.Соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хэрэгжилт: "Улаанбаатар театр" ОНӨТҮГ нь 2023 онд гадаад харилцааны хамтын ажиллагааны хүрээнд нийт гадаадын 5 оронтой /БНСУ-2, БНТУ-1, БНФУ-1, БНХАУ-1, БНКиру-1/ 6 удаагийн уулзалт хийн, хамтын ажиллагааны гэрээ-2, хамтарсан тоглолт 4-ийг амжилттай зохион байгуулж ажилласан. Цаашид, 2024 онд БНХАУ болон Киргиз улстай албан уулзалтын үеэр хамтын ажиллагааны гэрээ, хамтарсан тоглолт хийхээр төлөвлөөд байна.



2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр БНСУ-ын Үндэсний хөгжмийн Нуримпан анбсамбльтай хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, тус чуулгын хөгжимчидтэй хамтарсан анхны тоглолтоо Улаанбаатар театрын тайзнаа тоглосон.





МөнБНСУлсын Олон улсын Нульто байгууллагатай амжилттай хамтын ажиллагааны гэрээ хийн Улаанбаатар театрын Үндэсний хөгжмийн "Хангарди" найрал болон Нульто байгууллагын уран бүтээлчдийн хамтарсан "Азийн уламжлалт хөгжмийн соёлын солилцоо" тоглолт Улаанбаатар театрын тайзнаа 2023 оны 9 сарын 28-ны өдөр амжилттай тоглож өндөрлөлөө.

Монгол-Францын төвтэй хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар театрын тайзнаа Монгол-Францын төв, МУК, Франц Улсын "Облик" цирк, Монголын "Пирамид" цирк, ШШГГ-ын харъяа "Соёмбо" чуулгын бүжигчдийн хамтарсан тоглолт 10 дугаар сарын 06-нд амжилттай тоглосон.

2023 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд БНТУ тунхагласны 100 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Улаанбаатар театр, Монгол Улсад суугаа Турк Улсын Элчин Сайдын Яамтай хамтран "Турк-Монголын Уламжлалт Ардын хөгжмийн соёлын солилцоо" тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Тус тоглолтод Турк ардын хөгжимчдийн төлөөлөл, авьяаслаг уран бүтээлчид болох Салих Гүндөгду, Синан Аяылдыз нар Туркийн үндэсний Баглама хөгжмийг үзэгч олонд танилцуулахын зэрэгцээ Улаанбаатар театрын "Хангарди" үндэсний хөгжмийн найралтай хамтран /Монгол ардын уламжлалт хөгжмийн зэмсгүүдтэй хослуулан/ уран бүтээлийн дээжсээсээ толилууллаа.



2023 оны 12-р дугаар сард БНХАУ-ын Элчин сайдын Яамны Соёлын асуудал хариуцсан төлөөлөгчтэй Улаанбаатар театрын Дарга Ю.Гэрэлбаатар, Захиргааны хэлтсийн дарга Б.Түмэндэлгэр нар албан уулзалт хийж, 2024 онд хоёр орны соёлын

харилцааны хүрээнд хамтарсан тоглолт хийх болон хөрөнгө оруулалтын талаар харилцан тохиролцоонд хүрсэн.



Мөн 2024 онд Киргиз улстай хамтын ажиллагааны санамж бичиг зурж, соёлын солилцооны хүрээнд хамтарсан тоглолт зохион байгуулахаар албан уулзалтын үеэр тохиролцон, төлөвлөөд байна. Мөн, БНУУ-ын Соёлын өдрийн үйл ажиллагаанд оролцсон. Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран Польш улсын ерөнхийлөгч, Франц улсын ерөнхийлөгчийн айлчлалын үеийн соёл урлагийн үйл ажиллагаанууд болон Гадаад хэргийн яамтай хамтран Төрийн гадаад арга хэмжээнүүдэд оролцон тоглосон.



2023 оны 09 дүгээр сард ӨМӨЗО-ны Хөх хотод зохиогдсон “Монгол-Хятадын экспо”-д зориулсан Хятад-Монгол-ОХУ-ын хамтарсан нээлтийн тоглолтонд Улаанбаатар театрын 19 уран бүтээлч ардын урлагаа сурталчлан гадаад, дотоодын үзэгч олонд толилууллаа.

2023 онд хөдөө орон нутгийн театруудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээг өргөжүүлж ажилласан. Жишээлбэл, Төв аймгийн “Монгол туургатан” театр, Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр, Дорноговь аймгийн “Саранхөхөө” театртай хамтын ажиллагааны гэрээ хийж хамтран ажилласан.



4.6 Уран бүтээлчдийн уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжиж, тэдний зохион байгуулсан тайлан тоглолтыг бүх талаар дэмжиж, хамтран ажиллана.

Хэрэгжилт: Морин хуур хөгжимчин А.Мөнгөний “Нутаг усны эгшиг” бие даасан тоглолтыг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 2 удаа 450 үзэгчдэд, 31-ний өдөр Даланзадгад хотод 1 удаа 800 үзэгчдэд амжилттай тоглож, нийт 1250 хүнд тоглолтоо толилуулсан. Тус тоглолтыг Улаанбаатар театрын хамт олон удирдлагын зүгээс бүрэн дэмжиж ажилласан.



2023.05.10-27-ны өдрүүдэд гоцлол дуучин Н.Бямбадорж “Ай даа хийморь” бие даасан уран бүтээлийн тоглолтоо Булган аймгийн 16 сумдаар тойрч тоглон 2000 гаруй хүнд үйлчилжээ. Тус тоглолтуудыг бүх талаар дэмжиж ажиллаа.



Улаанбаатар театрын гоцлол дуучин О.Анхчимэг мартагдсан уртын болон ардын дууг судлан, сурч уран бүтээлийнхээ жагсаалтыг нэмсээр ирсэн. Тэрээр энэ 12 сард “Уяхан замба тивийн наран”, “Алтаргана”, “Биндэръяа хан уул” зэрэг дуунуудыг шинээр сэргээн дуулж нийт 24 дуутай хос цомог гарган олны хүртээл болгож байгаа Улаанбаатар театрын шилдэг уран бүтээлчдийн нэг юм.



4.7.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах.



Хэрэгжилт: Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу зарцуулан үйл ажиллагаагаа явуулж, өр төлбөр үүсгэлгүй хэмнэж зарим зардлуудад хязгаар тогтоосон бөгөөд албан тасалгаануудын дотоод дулааныг хэвийн хэмжээнд барьж, их танхимын дулааныг зөвхөн тоглолтын үйл ажиллагаатай үеэр дулаан нэмэлтээр өгч ажиллаж байна. НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланг хүргүүлэн баталгаажуулан ажилласан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж өр, авлага үүсгэхгүй байх тал дээр анхаарч урьд оны 7,687,304 төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан.

4.8.Албан хаагчдыг мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамруулна. /Цахим болон танхим/

Хэрэгжилт: Албан хаагчдын мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, ажлын бүтээмжээ дээшлүүлэх, илүү чадваржих, өөр мэргэжлээр хөрвөх чадвартай болгох үүднээс сургалтанд хамрагдахад нь байгууллагын зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжгүй байдаг учир ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж суралцах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх үйл ажиллагааг бүрэн дэмжиж ажилладаг. 2023 онд ийнхүү ахисан шатны сургалтад суралцаж байгаа 6 албан хаагчийн ажлын цагийг уян хатан болгож, суралцах нөхцөл бололцоог хангаж ажилласан. Мөн, Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Цолмончимэгийг 6 удаагийн танхимын, 3 удаагийн цахим чадавхижуулах сургалтад, Нягтлан бодогч, Нярав нар 7 удаагийн цахим, 5 удаагийн танхимын, Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр 6, Хүний нөөцийн менежер Л.Одгэрэл танхимын 6, цахимаар 8 удаагийн, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал мэргэшүүлэх 1, танхимын 2, цахим 2, нярав Ч.Байгалмаа мэргэшүүлэх 1, цахим 2 удаагийн сургалтад хамрагдсан. Шинээр ажилд орсон 18 албан хаагчид танилцуулах сургалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан.

Бакалавр, магистр, докторын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан. Эвэр бүрээ хөгжимчин Б.Баасансүрэн Соёл урлагийн их сургуульд докторын, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц Соёл урлагийн их сургуульд магистрын, ятга хөгжимчин Э.Намуундарь Соёл урлагийн их сургуульд магистрын зэрэг горилохоор суралцаж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргалыг “ХАБЭА” ХХК-ийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

Театрын “Сургалтын хөтөлбөр-2023” (Зохион байгуулах ажлын тоо-9), “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөө” (зохион байгуулах ажлын тоо-17)-г 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр театрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Жилийн эцсийн байдлаар Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй, Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний 17 ажлыг 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.





4.9. Театрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, үйлчилгээний соёл, харилцааны соёл, эрүүл мэндийн талаар сургалтыг зохион байгуулна.

Хэрэгжилт: Театрын даргаар 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан “Улаанбаатар театрын албан хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөө”-нд тусгагдсан “Байгууллагын үйлчилгээний соёл, албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дүүргийн албан бус Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулж, 38 албан хаагчийг хамруулсан.

2023 оны 10 дугаар сарын 23,25-ны өдрүүдэд нийт албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль, УБ театрын Ёс зүйн дүрэм, УБ театрын дотоод журам, Ёс зүйн хэм хэмжээний тухай 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 89 албан хаагчийг хамруулсан.



4.10. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай хуулийг мөрдөж ажиллана.

Хэрэгжилт: Театрын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын ёс зүй, дотоод уур амьсгал, хоорондын харилцаа, ажлын байрны сахилга бат-дэг журам, архидан согтууралт, ялгаварлан гадуурхалт, бэлгийн болон ажлын байрны дарамтыг үл тэвчих зэрэг асуудлуудад тулгуурласан ажлуудыг зохион байгуулж, албан хаагчдад анхааруулга санамжийг тухай бүр өгч, мэдээллийг самбарт байршуулан хяналт тавьж ажилласан. Театрын даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/19 пүгээр тушаалаар театрын Ёс зүйн зөвлөлийн 5 гишүүнтэй шинэчлэн байгуулж, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан. Шинээр баталсан ёс зүйн дүрмийг www.ubtheatre.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан, дүрэм журмын хавтас нээж албан хаагчдад танилцуулсан.

Тус ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдад ёс зүйн талаар таниулга сурталчилгааг тогтмол хийж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төрийн албанд ажиллах бөгөөд ёс зүйн үнэт зүйл, зарчим, хэм

хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүйгээр ажиллахад анхаарч ажилласан. 2023 оны 10 дугаар сарын 23,25-ны өдрүүдэд нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, УБ театрын Ёс зүйн дүрэм, УБ театрын дотоод журам, Ёс зүйн хэм хэмжээний талаар 2 удаагийн сургалтыг 89 албан хаагчийг хамруулж ажилласан. Мөн, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшлийн 7/4/10 Пүрэв гарагийн вебинар сургалтанд албан хаагчдаа хамруулж, 2 удаагийн сургалтанд 32 албан хаагчийг хамруулж ажилласан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан 4 албан хаагчийг Ёс зүйн зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэний дагуу театрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. Мөн, хөнгөн зөрчил гаргасан 3 албан хаагчид эхний удаагийн сануулга өгч, дахин ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахыг анхааруулсан.

4.11.Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангуулж, үйлдвэрлэлийн осолгүй ажиллана.

Хэрэгжилт: Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангуулж, үйлдвэрлэлийн осолгүй ажиллаж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр ажилд гарахын өмнө тайз ангийн ажилчдад өгч, зааварчилгааны дэвтэр дээр гарын үсэг зуруулж, ажиллаж хэвшсэн. Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол гараагүй. Улаанбаатар театр шинээр Бөмбөгөр театртэй болсонтой холбогдуулж уг театрт ажиллах Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, аюулгүй ажиллагааны анхааруулах тэмдгийг тайзны арын аюул осол гарч болзошгүй хэсэг байрлуулж, урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж ажилласан.



4.12.Байгууллагын албан хаагчдыг эрт илрүүлгийн шинжилгээнд хамруулж, эрүүл мэндээ сахин хамгаалахад зориулж ажлын цагийн зохицуулалт хийж ажиллана.

Хэрэгжилт: Эрүүл мэндийн Яамнаас хэрэгжүүлж буй иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах хөтөлбөр “Эрт илрүүлэг”-т орох 22 албан хаагчийг ажлаас чөлөөлж, зохицуулалт хийж ажилласан. Мөн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны хийх ажлын төлөвлөгөө”-нд тусгасны дагуу 29 албан хаагчийг цус, шээс, биохимийн шинжилгээнд хамруулах ажлыг Сонгинохайрхан дүүргийн “Арвин мэнд” өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Тус шинжилгээгээр эмгэг өөрчлөлт илэрсэн албан хаагч байхгүй.

Мөн, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэгдсэн эрүүл мэндийн төв эмнэлэгтэй хамтран Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 340 дугаар тушаал, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14,1 дэх хэсэг удирдлага болгон нийт албан хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2023 оны 11 дүгээр сарын 07, 08, 09 ны өдрүүдэд бүрэн хамруулж дууслаа. Үзлэгээр илэрсэн ясны

сийрэгжилттэй, өөх тосны хэмжээ ихэссэн, зүрх судас, цусны даралт ихсэх хандлагатай, цөсний чулуужилттай зэрэг шалтгаант өөрчлөлтэй албан хаагчдад эмчийн зөвлөгөө өгч ажилласан.

4.13.Архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэнэ.

Хэрэгжилт: Театрын албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг edoc.ulaanbaatar.mn домайн нэр бүхий онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж, цахим хэлбэрээр үүссэн баримт бичгийг тоон гарын үсгээр баталгажуулж, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэж ажилласан.Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтанд цахим хувь үйлдэх тухай” А/52 дугаар захирамжын дагуу 2019-2022 оны захирамжлалын баримт бичгийн хавсаргасан цахим хувь болон хавсралтуудын бүрдэл, үг үсгийн алдаанд нягтлан шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж нөхөж 2022 оны захирамжлалын баримт А тушаал /01-49/ 208 хуудас, Б тушаал /01-70/ 97 хуудас бүхий баримтууд цахимаар хүлээн авч <https://arch.ulaanbaatar.mn/> нэгдсэн системд нөхөн бүрдүүлэлт хийн Төрийн архивын хэлтэст хүлээлгэн өгсөн. 2022 оны цаасан суурьтай баримтуудаа байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийж хүлээн авч байнга түр 70 жилээр төрөлжүүлэн бүртгэж ажилласан.

4.14.Ирсэн, явсан хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.

Хэрэгжилт: Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, судалж шийдвэрлэх, хариу өгөх болон мэдээлэл-лавлагаанд шаардлагатай бүх баримт бичгийг хүлээн авч, бүртгэн үйл ажиллагааг edoc.ulaanbaatar.mn онлайн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар /албан бичгийн индекс -0.4089/ **нийт 233 албан бичиг ирснээс хариутай-66хариугүй -166 /хугацаандаа хаасан -232, хугацаа хэтэрч хаасан-1, шийдвэрлэлтийн хувь-99.40%/, байна. Нийт явсан бичиг 183 /хариутай бичиг 3, хариугүй бичиг 180 шийдвэрлэлтийн хувь-100% байна**

Хариугүй албан бичиг 166 ирснээс 100%-тай хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Баримт бичигт шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна

| № | Хяналтын нэр | Хувиар өгсөн байдал | | | | | | Нийт хэрэг үзүүлэн байдал | | | | | | Хувиар өгсөн байдал | | | | | |
|---|---|---------------------|---------------------|------------|---------------------|------------|---------------------|---------------------------|---------------------|------------|---------------------|------------|---------------------|---------------------|---------------------|------------|---------------------|------------|--|
| | | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | Уривтар | Хувиар өгсөн байдал | | |
| 1 | Бичгийн үндсэн баримт бичгийн үндсэн баримт | 202 | 100 | 100 | 202 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | |
| 2 | Хариуцаж байгаа бичгийн үндсэн баримт | 1 | 0 | 0 | 1 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.00 | 1 | 1 | 0 | 0 | 0 | |
| 3 | Уривтар бичгийн үндсэн баримт | 1 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.00 | 1 | 1 | 0 | 0 | 0 | |
| | Нийт | 203 | 100 | 100 | 203 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | |

Улаанбаатар талар СИ НТҮГ Аудит /Өнөөгийн үнэмлэхүй гүйцэтгэл/ 2023-08-31

МЭДЭЭ ХАНАСАН МҮЧЛЭЛИЙН МЕНЕЖЕР Э. ДУЛГИЯАМ 2023-08-31

МАРГИЙН ГЭМБЭЭ 0.4089

ЯВУУЛСАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
2023.01.01-2023.12.31

Улаанбаатар хот

| Д/А | Халтас нэгж | Нийт | Хариуцаа | Хариугүй | Хугацаанд нь хариу ирүүлсэн | Хугацаа хэтрүүлж хариу ирүүлсэн | Шийдвэрлэж шатаагдаа | Хугацаа хэтэрсэн, хариу ирээгүй | Шийдвэрлэлтийн хувь |
|---|---|------------|----------|------------|-----------------------------|---------------------------------|----------------------|---------------------------------|---------------------|
| Улаанбаатар хотын ОНӨТҮГ | | | | | | | | | |
| Нийслэлийн Орон нутгийн өмчтөг төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны эхний үр дүнжилсэн үнэлгээ ОНӨТҮГ | | | | | | | | | |
| 1 | Захирагч, эдийн засаг, захирал, захирлын хэлтэс | 163 | 0 | 163 | 0 | 0 | 0 | 0 | 100.00% |
| 2 | Мэргэжилтэн, бичигч хариуцаагчид хариуцаа | 20 | 3 | 17 | 0 | 0 | 0 | 0 | 100.00% |
| | Байгууллагын нийт | 183 | 3 | 180 | 0 | 0 | 0 | 0 | 100.00% |


ХЯНАЛТЫН
ГЭВЭЭНИЙ АЖЛААСЫН
МАЛЧИ 100% ӨНӨТҮГ 100% ӨНӨТҮГ

4.15.Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд зөрчилгүй шийдвэрлэж ажиллана.

Хэрэгжилт: 2023 оны жилийн эцсийн байдлаар театрын захиргаанд хандаж, албан хаагчаас 3 буюу бүжигчин Т.Цэндсүрэнгээс гадаадад гэр бүлээрээ ажиллах амьдрах болсон шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөлөгдөх, Тайзны машинист Р.Сийлэгмаа өндөр насны тэтгэвэр тогтоолгож, буцалтгүй тусламж авах, Шанз хөгжимчин Б.Гэрэлтуяагаас гэрээт албан хаагчаар ажиллах хүсэлт ирүүлсэн. Мөн иргэнээс 1 өргөдөл буюу иргэн С.Ширчмаа маркетингийн менежерээр ажиллах, нийт 4 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж, өргөдлийн хариуг өгсөн. Өргөдөл шийдвэрлэлттэй холбоотой гомдол, санал гараагүй.

4.16.Байгууллагын хагас, бүтэн жилийн тайлан мэдээнд хяналт шинжилгээ хийнэ. (Илтгэх хуудас, 206-р тогтоолоор үнэлэх)

Хэрэгжилт: Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Цолмончимэг албан хаагч тус бүрээс авч нэгтгэн, ERP систем дэх Хяналт шинжилгээ цэсээр тайлагнасан. Тус тайланд 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж ажилласан.



2023 оны эхний хагас жилийн тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн мэргэжилтний дүгнэлтээр: Театрын удирдлага Нийслэлийн Засаг даргатай байгуулах “Хариуцлагын гэрээ” түүний хавсралт болох “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 41 зорилт дэвшүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж ажиллахаар төлөвлөсөн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар дээрх 41 ажлаас 39 ажлыг тодорхой хувийн гүйцэтгэлтэй хангаж ажилласан байна. Арга хэмжээ тус бүрээр дүгнэвэл 100%-ийн биелэлттэй 19, 80%-

3, 81.8%-1, 75%-2, 70%-1, 66.7%-1, 66.6%-1, 60%-3, 50%-5, 30%-1, 25%-1, 20%-1, 0%-2 ажил байна. Биелэлтийн дундаж хувь 75.1%. Үүнээс харахад, жилийн эцэс хүртэл гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг 100%-ийн гүйцэтгэлтэй биелүүлэх боломжтой. 50-аас доош хувийн гүйцэтгэлтэй 5 ажил, арга хэмжээнд анхаарлаа хандуулж ажиллалаа. Эдгээр ажлууд нь мод тарих, сэтгэл ханамжийн судалгаа авах, "Хотын соёл" нөлөөллийн аян зохион байгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах, цахим Улаанбаатар төслийн хүрээнд цахим мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах зэрэг ажлууд байлаа. Энэхүү ажлуудыг хариуцсан албан хаагчдад ажлаа эрчимжүүлэх тал дээр анхаарч ажиллах чиглэлийг өгч ажиллав. Мөн, нийт ажлуудад төлөвлөлтийн алдаа их байгаа учраас арга хэмжээ тус бүрийг тодорхой түвшинд үнэлж, дүгнэхэд хүндрэлтэй байна. Иймээс, ирэх оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахаас өмнө захиргааны албан хаагчдыг сургалт арга зүйгээр хангах саналыг дэвшүүлэв. Мөн, цаашид анхаарах асуудал нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, ажил, арга хэмжээг маш тодорхой үр дүнд суурилсан хэмжигдэхүйц хэлбэрээр төлөвлөх шаардлагатайхэмээн дүгнэсэн байна. Энэхүү дүгнэлтийг үндэслэн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлагнахдаа анхаарч ажилласан.

4.17. Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.

Хэрэгжилт: Улаанбаатар театрын "Сургалтын хөтөлбөр-2023" (Зохион байгуулах ажлын тоо-9), "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөө" (зохион байгуулах ажлын тоо-17)-г 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр театрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Жилийн эцсийн байдлаар Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй, Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний 17 ажлыг 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр Улаанбаатар театрын даргын 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн багц хөтөлбөр"-ийг батлан хэрэгжилтийг хангаж ажилладаг. Энэхүү хөтөлбөртөө албан хаагчдын сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг багтаасан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын жилийн төсөвт тусган санхүүжүүлж ажилласан.

| Шийдвэрийн дугаар | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, батлагдсан төсөв | Гүйцэтгэлээр /Сая төгрөг/ |
|--|---|---------------------------|
| Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын даргын 2022.02.11-ний өдрийн А/11 дүгээр тушаал, | Албан хаагчдын ажлын ур чадвар, үр дүнг үнэлж, урамшуулсан байдал. Төсөв: 96,877,000 төгрөг | 96,3 |
| | Нэг удаагийн тэтгэмж, буцалтгүй тусламж Төсөв: 6,000,000 сая төгрөг | 2,0 |
| | Хөгжим тоног төхөөрөмжийн запас сэлбэг Төсөв: 10,243,700 төгрөг | 9,9 |
| | Засвар үйлчилгээ, Урсгал засвар Төсөв: 3,000,000 төгрөг | 3,0 |
| | Бичиг хэрэг: төсөв: 714,900 төгрөг | 2,2 |
| | Бусад: Төсөв: 2,748,000 төгрөг | 2,6 |
| | Нийт: 119,583,600 төгрөг | 116,0 |

Суралцах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх албан хаагчийг дэмжиж ажиллах талаар дэмжлэг: Бакалавр, магистр, докторын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан. Эвэр бүрээ хөгжимчин Б.Баасансүрэн Соёл урлагийн их сургуульд докторын, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц Соёл урлагийн их сургуульд магистрын, ятга хөгжимчин Э.Намуундарь Соёл урлагийн их сургуульд магистрын зэрэг горилохоор суралцаж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргалыг "ХАБЭА" ХХК-ийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

Нэг удаагийн тусламж дэмжлэг: Театрын Хөдөлмөрийн Дотоод журамд тусгасны дагуу ар гэрт нь гачигдал гарсан 3, хүнд хэлбэрийн өвчтэй болон өртөг өртөгтэй мэс заслын эмчилгээ хийлгэсэн 2, нийт 5 албан хаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгов. Тусламжаар олгосон мөнгөн дүн 2.050.000 төгрөг.

| № | Албан хаагчийн нэр | Албан тушаал | Шалтгаан | Мөнгөн дүн |
|---|--------------------|------------------|---|------------|
| 1 | Б.Сувд-Эрдэнэ | Архивын эрхлэгч | Эмчилгээний зардалд | 500.000 |
| 2 | Б.Сувд-Эрдэнэ | Архивын эрхлэгч | Төрсөн эцэг нас барсан | 300.000 |
| 3 | Б.Ганчимэг | Бүжигчин | Удаан хугацаагаар хүнд өвчтэй байгаа ээжийгээ асарч сувилахад зориулсан тусламж | 350.000 |
| 4 | Б.Бат-Өрнөх | Гоцлол хөгжимчин | Төрсөн эцэг нас барсан | 300.000 |
| 5 | С.Эрдэнэцэцэг | Нягтлан бодогч | Өндөр өртөгтэй мэс заслын төлбөрт дэмжлэг үзүүлэх | 600.000 |

Мөн жил бүрийн 06 дугаар сарын 01-нд болдог Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу Хүүхдийн баяраар театрын албан хаагчдын 95 хүүхдэд Ханбүргэдэй их дэлгүүрийн хүүхдийн бэлгээр албан хаагчдынхаа хүүхдүүдэд бэлэг барьсан. Тус үйл ажиллагаанд зориулагдсан 3.027.463 төгрөгийн зардлыг театрын даргын тушаалаар, зохих журмын дагуу байгууллагын төсвөөс гаргаж санхүүжүүлсэн.

Мэргэжлийн уралдаанд гаргасан уран бүтээлчдийн амжилт: Улсын болон олон улсын хэмжээний мэргэжлийн уралдаанд театрын уран бүтээлчид ур чадвараа сорьж оролцсоор ирсэн. Үүний үр дүнд уран бүтээлчдийн чансаа дээшилж, мэргэжлийн хувьд салбартаа танигдан манлайлан ажиллах боломж нээгддэг. 2023 оны хувьд 10 уран бүтээлч мэргэжлийн өндөр шалгуур бүхий уралдаанд амжилттай оролцлоо. Театрын хувьд энэхүү уралдаанд оролцож байгаа уран бүтээлчдээ бүх талаар дэмжиж ажилласан. Тэдний амжилтаас дурдвал, Бүжигчин Г.Энхжаргал Хэнтий аймагт зохион байгуулагдсан МУУГЗ, бүжиг дэглээч А.Санжаасүрэнгийн нэрэмжит Гоцлол бүжигчдийн улсын уралдаанаас Гуравдугаар байр, Гоцлол хөгжимчин Б.Мягмарцэрэн Монгол Улсын Төрийн дээд шагнал Чингис хаан одонт, Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит "Мэргэжлийн дуучид, үндэсний хөгжимчдийн олон улсын гуравдугаар уралдаан"-ы Мэргэжлийн хөгжимчин төрөлд "Хоёрдугаар байр", Гоцлол дуучин О.Анхчимэг Дорнод аймагт болсон Уртын дуу дуулаачдын улсын уралдаанд Тэргүүн байр, "Монголын үндэстэн ястны ардын богино дуу

дуулаачдын олон улсын уралдаан"-ы тэргүүн байр, Уртын дуу дуулаачдын "ҮЛЭМЖИЙН ЧАНАР" Олон улсын Анхдугаар уралдааны Мэргэжлийн ангилалд гуравдугаар байр, Гоцлол дуучин Т.Баянжаргал Монголын орчин цагийн хөгжмийн урлагийг үндэслэгч алдарт гавьяат дууч Магсар Хурцын Дугаржавын нэрэмжит Улсын уралдааны "Гранпри", Монгол улсын ардын жүжигчин Чулуунбаатарын Шархүүгийн нэрэмжит Монгол ардын уртын дуу, Ардын богино дуу дулаачдын улсын уралдааны уртын дууны тэргүүн байр, О.Анхчимэг дэд байр, Гоцлол бүжигчин Б.Норовбанзад МУАЖ Д.Нанжидын нэрэмжит "БИЕЛГЭЭ" ардын бүжгийн олон улсын анхдугаар уралдаанаас 2 төрөлд тэргүүн байр, Бүжигчин Б.Цэвэлсүрэн Ойрадын бий биелгээ төрөлд тэргүүн байрыг тус тус эзэлсэн байна.

Энэхүү уран бүтээлчдээ театрын захиргаа, удирдлагын зүгээс тодорхой хэмжээнд урамшуулж, зарим уран бүтээлчдийн төрийн одон медалиар шагнуулахаар тодорхойлсон.



Мөн, Гоцлол хөгжимчин Г.Бат-Өлзий, лимбэ хөгжимчин Б.Батжаргал нар Авьяаслаг Монголчууд-2023 телевизийн шоунд амжилттай оролцож, шилдэг 8 оролцогчийн нэгээр шалгарсан.



5.Бусад

- Дотоод журамд заасны дагуу албан хаагчдад өдрийн хоолны хөнгөлөлт 5000, унааны хөнгөлөлт өдөрт 500 төгрөгөөр тооцон сар бүр олгосон.
- Ажлын байрны таатай орчин, ажиллах нөхцлийг сайжруулахаар өрөө тасалгааны гэрэлтүүлэг, чийгшил, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарч зөрчил дутагдал гарсан даруйд зөрчил, тасалдлыг арилгуулж ажилласан.
- Эрүүл мэндийн Яамнаас хэрэгжүүлж байгаа иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах хөтөлбөр "Эрт илрүүлэг"-т орох 22 албан хаагчийг ажлаас чөлөөлж, зохицуулалт хийж ажилласан. Мөн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны хийх ажлын төлөвлөгөө"-нд тусгасны дагуу 29 албан хаагчийг цус, шээс, биохимийн шинжилгээнд хамруулах ажлыг Сонгинохайрхан дүүргийн "Арвин мэнд" өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Тус шинжилгээгээр эмгэг өөрчлөлт илэрсэн албан хаагч байхгүй. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэгдсэн эрүүл мэндийн төв эмнэлэгтэй хамтран Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20 ны өдрийн 340 дугаар тушаал, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14- дүгээр зүйлийн 14,1 дэх хэсэг удирдлага болгон нийт албан хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2023 оны 11 дүгээр сарын 07, 08, 09 ны өдрүүдэд бүрэн хамруулж дууслаа. Уг үзлэгээр албан хаагчдад ноцтой өвчний шинж тэмдэг илрээгүй болно.
- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 57 албан хаагчид, төрийн албанд ажилласан жилд ногдуулан сар бүр тооцон олгосон. Одоогоор, зэргийн нэмэгдлийг 2, Нийтийн тээврийн хөнгөлөлтийг 59, хавсран ажилласны нэмэгдлийг 2, өдрийн хоолны хөнгөлөлтийг 63 албан хаагчид олгож байна.
- Хөгжимчдийн хөгжмийн запас сэлбэг, бусад тоноглолоор байнга хангаж ажилласан.
- Цалингийн зээл авахаар хүсэлт гаргасан албан хаагчдад тухай бүр байгууллагын зүгээс тодорхойлолт гаргаж ажилласан.
- Албан хаагчдын нийгмийн байдлыг тодорхойлох судалгааг 2023 оны 10 сарын 15-наас 11 сарын 01-ны хооронд GOOGLE FORM хэлбэрээр явуулсан. Тус судалгааны дүнд үндэслэн 2024 онд албан хаагчдын нийгмийн байдалд тохирсон ажил, арга хэмжээ зохион байгуулахад анхаарч ажиллахаар төлөвлөсөн.
- Мөн, албан хаагчдын дунд ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг явуулсан. Энэхүү судалгаагаар Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, ажлын тав

тухыг хангах тал дээр байнга анхаарч ажиллахад юу дутагдалтай, юунд анхаарч ажиллахад дөхөм болохуйц үр дүнтэй судалгаа болсон. Ажлын байрны таатай орчинд нөлөөлөх 5 хүчин зүйлд тулгуурлан асуулгын явуулсан. Үүнд, 1-т ажилдаа сэтгэл ханамжтай байдал- 82.5%, 2.Театрын удирдлагын хандлага сайн -85%, орчин, өрөө тасалгааны тохижилт сэтгэлд нийцдэг-22.5%, ажлын багаж хэрэгслийн хангалт сайн-15%, хамт олны уур амьсгал сайтай-75% гэж дүгнэсэн байна. Энэ 5 үзүүлэлтээс нэгтгэж дүгнэвэл албан хаагчдын ажлын байранд сэтгэл ханамжтай байх нөхцөл 54.7% нь ажлын байрандаа сэтгэл ханамжтай байдаг гэсэн үг. Иймд энэ түвшинг ахиулахын тулд 2024 оны ажлын төлөвлөгөөнд албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр дорвитой ажил зохион байгуулах нь зүйтэй. Ялангуяа өрөө тасалгааны тохижилт, ажлын багаж хэрэгслийн хангал, цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарлаа хандуулах нь чухал байна.

4.18. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих:

Хэрэгжилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг угтан Улаанбаатар Театр Хан-Уул дүүргийн Айцын аманд байгууллагаараа тарьсан модны тоо 89, Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Баяндөхөмд 103 мод тарьсан бөгөөд энэ 05 дугаар сард тарьсан модны арчилгаа, хаврын усалгааг хийж ажилласан.



2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот – Иргэний оролцоо” намрын мод тарих аяны хүрээнд театрын албан хаагчид хуваарийн дагуу “Айц”-ын аманд тарьсан 40ш модны арчилгаа /модны нүхэнд ургасан зэрлэг өвсийг зулгааж, хог хаягдлыг цэвэрлэн, усалгаа хийн/, шинээр 20ш мод нөхөн тарилт хийлээ.



221

Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, ногоон хот, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс иргэн бүр мод тарихыг уриалж байгууллагын сошиал хуудсаар дамжуулан иргэдэд зориулсан постууд хийж ажилласан байна.

4.19.Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах.

Хэрэгжилт: Нийслэлийн Засаг даргатай байгуулсан “Хариуцлагын гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд Театрын дарга бэлэн байгаа бөгөөд одоогоор Нийслэлийн Засаг даргыг төлөөлж, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох асуудал гараагүй байна.

4.20.Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.

Хэрэгжилт: Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд соёл урлагийн салбар, ялангуяа нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллага болох “Улаанбаатар театр”-ыг хөгжүүлэх 2 санал боловсруулж, батлуулаад хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1.“Улаанбаатар театр”-ын хүний нөөцийг нэмэгдүүлэх, хөрвөх чадвар бүхий мэргэжлийн уран бүтээлчдийг 3 чиглэлд хуваан ажиллуулах.(Нийслэлийн Засаг даргын 2023.03.20-ны өдрийн А/263 дугаар захирамж)

2.Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Соёлын жил, 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгосонтой холбогдуулан, гадаад дотоодын жуулчдад зориулсан тайзны томоохон уран бүтээлд уран бүтээлийг дэмжиж ажиллах. (Нийслэлийн Засаг даргын 2023.03.28-ын өдрийн А/291 дүгээр захирамж).

Түүнчлэн, Театрын удирдлага Нийслэлийн Засаг даргын Тамгын Газраас соёл урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа 8 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтан ажилласан.

4.21.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах

Хэрэгжилт: 2.21 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ-ЫН танхимд “АНХААРАЛТАЙ – МЭДЛЭГТЭЙ – МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙЯ” хууль эрх зүйн танин мэдэхүйн сургалт зохион байгуулав. Тус арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус, их дээд сургуулийн 1 дүгээр курсийн оюутан залуучууд Сүхбаатар дүүргийн 8 хорооны иргэд Улаанбаатар театрын алба хаагчид зэрэг нийт 300-400 хүнд дээрх байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, лекц, асуулт хариулт, өнөөгийн нийгэмд тулгамдаж буй гэмт хэрэг зөрчлөөс бидний ирээдүй болсон хүүхэд залуусаа хэрхэн яаж хамгаалах гэдэг тодорхой төрлийн тэдний үеийнхэнд нэн хэрэгтэй мэдлэг мэдээллээр хангах, Мэргэжлийн урлагийн байгууллага нь соёл урлагийн ажлаараа соёлын боловсрол олгох түүнийг түгээн дэлгэрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай хослуулан хийснээр зорилтот бүлэгт амжилттай хүрч чадсан гэж бид дүгнэж байна.

Энэхүү арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд оролцож, дохионы хэлээр сургалт, лекц орсноороо онцлог юм. Бид энэхүү арга хэмжээг цаашид илүү олон албан байгууллага болон төрийн бус байгууллага хүүхэд залуучуудыг хамруулан арга хэмжээний цар хүрээг томруулах зорилготой байна.



4.22 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Хэрэгжилт: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар НЗДТГ-аас зохион байгуулсан сургалтанд 3 албан хаагч хамрагдсан. Мөн байгууллагын "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" чиглэлийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр театрын даргаар батлуулсан. Хэрэгжүүлж ажиллах ажлын тоо-7, Хариуцах ажилтан Дотоод ажил, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн Л.Цолмончимэг. Тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 ажлын хэрэгжилтийг хангаж ажилласан. Байгууллагын дотоод журмын 3.6.1 дэх хэсэгт Жендэрийн ялгаатай байдал үзүүлж ялгаварлан гадуурхах болон ажлын байрны тэвчишгүй орчин үүсгэхийг хатуу хориглоно гэсэн заалтыг тусгаж өгсөн.

Улаанбаатар театр нь 44 эрэгтэй 25 эмэгтэй албан хаагчтай бөгөөд жилд 1 удаа статистик мэдээг үзүүлэлтээр гаргаж Нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлж ажилладаг болно. Жендэрийн үндэсний Хорооноос 2023 оны 11 дүгээр сарын 25-аас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д нэгдэж байгууллага дотроо шторк байрлуулж, Улаанбаатар театр Фэйсбүүк пэйжээр сурталчилсан.

Систем хариуцсан ажилтан
Н. ERP Admin



ТАВДУГААР ХЭСЭГ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ -5:

5.1.2023 онд дэвшүүлсэн зорилтоо тодорхойлж, зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болох хүрэх түвшинг тооцож тусгайлан оруулах.

Хэрэгжилт: Театрын удирдлага Нийслэлийн Засаг даргатай байгуулах “Хариуцлагын гэрээ” түүний хавсралт болох “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 6 зорилт, 41 ажил дэвшүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж ажиллахаар төлөвлөсөн. 2023 оны жилийн эцсийн байдлаар дээрх 41 ажлыг тодорхой хувийн гүйцэтгэлтэй хангаж ажилласан. Энэхүү гүйцэтгэлийн үр дүнг 206 дугаар тогтоолын 6.2-т заасан аргачлалаар тооцвол 96,7%-ийн гүйцэтгэлтэй хангаж ажилласан байна. (Суурь түвшин -30, зорилтот түвшин-41, хүрсэн түвшин-41)

$$\text{Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт} = \frac{41-30}{41-30} \times 100\% = 100\%$$

Бүтээгдэхүүн тус бүрээр дүгнэвэл 100%-ийн биелэлттэй 37, 80%-1, 85%-1, 50%-2 ажил байна. Дундаж үнэлгээ 96.7%

5.2. Иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн шинэ уран бүтээл туурвих болон урын санд байгаа бүтээлийг сэргээх, хүүхдэд зориулсан уран бүтээл туурвиж, үндэсний уламжлалт соёл, дэлхийн улс үндэстний урлагийг сурталчилж олон нийтийн хүртээл болгоно.

Хэрэгжилт: Шинээр төлөвлөн хийгдэх 4 том бүтээл болон уран бүтээлчдийн бие даасан тоглолтуудыг зохион байгуулах ажлуудыг хийж, иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн, хүүхдэд зориулсан, үндэсний уламжлалт соёлоо гадаад дотоодын үзэгчдэд сурталчилж, олон нийтийн хүртээл болгохоор ажиллаа. Тайлант хугацаанд хүүхдэд зориулсан “Дэлхийн мод” синтез жүжиг, мөн Muppet театртэй хамтран хүүхдэд зориулсан “Зөрүүд Гринч” жүжгүүдийг тавьж олны хүртээл болгоод байна. Урлагийн захиалгат 181 удаагийн тоглолт, өөрийн тайзнаа 37 удаагийн тоглолтыг зохион байгуулж ойролцоогоор 50.000 гаруй үзэгчдэд хүрч үйлчилжээ.

Ерөнхийлөгчийн Тамгын Газартай хамтран Монгол улсын Ерөнхийлөгчийн захиалсан гадаад, дотоодын зочдод хүндэтгэл үзүүлэх ажилд 13 удаа урлаг соёлоор үйлчлэн 850 гаруй хүнд тоглолтоо хүргэж ажилласан.



2023 оны 09 дүгээр сард ӨМӨЗО-ны Хөх хотод зохиогдсон “Монгол-Хятадын экспо”-д зориулсан Хятад-Монгол-ОХУ-ын хамтарсан нээлтийн тоглолтонд Улаанбаатар

театрын 19 уран бүтээлч ардын урлагаа сурталчлан гадаад, дотоодын үзэгч олонд толилууллаа.



5.3. Нийслэлийн өмчийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авна.

Хэрэгжилт: Томоохон театр урлагийн байгууллагын хувцасны шкафны стандарт өндөр нь 2,1 метр гүн нь 0,6м байдаг бөгөөд ихэнх хүмүүсийн өндөрт хамгийн тохиромжтой хэмжээ байдаг ба дааширны хувьд үрчлээсгүй байлгахын тулд хамгийн багадаа 165-180 см хуваалттай хийлгэснээр олон төрлийн хувцсыг эмх цэгцтэй үрчлээ болгож засаж янзлан тохижуулж шкаф бүрийг тоосны хамгаалалттай хөшигтэй болгосон. Илүү өргөн хаалга нь нугас болон гүйдэг хаалганы замд ачаалал өгч хурдан эвдрэх эрсдэлтэй учраас шкаф бүрийг хөшигтэй болгосон. Гуталны тавиурын хувьд өндөр нь маш чухал байдаг. Гутлыг зөв хадгалахын тулд тавиурын өндрийг 18-20см байх ба өвдөг хүртэл хадгалж байршуулахаар хаалгагүй хийхэд тохиромжтой ба хөлсний үнэрийг гадагш нь нэвтрүүлэх зорилготой хийлгэсэн.



Хамтран ажилладаг байгууллагаас гэрээний дагуу техник хэрэгслийг нийлүүлж хүлээн авсан. 1 давхарын жүжигчдийн өрөөний бүрэн засвар хийгдэж, нүүр будгийн ширээ болон сандлуудыг шинээр авч тохижуулсан.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2/485 албан бичгийн дагуу худалдан авсан хөрөнгийг журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэж зориулалтын дагуу хувцас тус бүрийг

чехол уутанд хийн хадгалсан. Мөн 3/534 албан тоотоор ирсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож зарим нэг хөрөнгийг нөхөн сэргээж сэлбэх арга хэмжээ авч ажилласан.

5.4. Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар ижил, төстэй гадаад дотоодын байгууллагатай хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллана.

Хэрэгжилт: Улаанбаатар хоттой Ах, дүүгийн харилцаат хотуудтай соёл урлагийн чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. Нийслэлийн Гадаад харилцааны хэлтсээс дэмжлэг авахаар албан бичгийг хүргүүлсэн. Гадаадын мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажил санаачлан зохион байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр БНСУ-ын Үндэсний хөгжмийн Нурипан чуулгатай хамтын ажиллагааны гэрээ үзэглэж, анхны хамтарсан анхны тоглолтоо “Улаанбаатар театр”-ын тайзнаа амжилттай зохион байгуулж 2 орны 450-аад иргэдэд тоглож сонирхуулсан.

Мөн БНСУ-ын Олон улсын Нульто байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ хийн Улаанбаатар театрын Үндэсний хөгжмийн "Хангарди" найрал болон Нульто байгууллагын уран бүтээлчдийн хамтарсан "Азийн уламжлалт хөгжмийн соёлын солилцоо" тоглолт Улаанбаатар театрын тайзнаа 2023 оны 9 сарын 28-ны өдөр амжилттай тоглож өндөрлөлөө.

Хөдөө орон нутгаас Төв аймгийн “Монгол туургатан” театр, Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр, Дорноговь аймгийн “Саранхөхөө театр”-тай хамтын ажиллагааны гэрээ хийж хамтран ажилласан.

5.5. Байгууллагын эд хөрөнгө техник тоног төхөөрөмж, тоноглол, хувцас чимэглэл, дүрс, гэрэл, дуу чимээний хэрэгслийн ашиглалтанд хяналт тавьж сайжруулна.

Хэрэгжилт: Байгууллагын эд хөрөнгө, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг тоглолт эхлэх бүрт хяналт тавьж ажилдаг. Мөн эвдрэл гэмтэл гарсан даруйд нь батлагдсан төсвийнхөө хүрээнд тоног төхөөрөмжийг цаг тухай бүрт нь засаж сэлбэж ажилласан. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны 02/485 тоот албан бичгээр НЗД-ын А/291-р дүгээр захирамжийн дагуу хөрөнгө худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 124 дүгээр тогтоолын дагуу төсвийн санхүүжилтийн эх үүсвэрт багтаан худалдан авч зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авсан.

НӨХГ-ын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 3/534 тоот албан бичгээр “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн хурлаар элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон эд хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоолгож нийт 193 нэр төрлийн 422,186,652.8 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон бүртгэлд тусгах үнийг тогтоож данс бүртгэлдээ бүртгэж аваад ажиллаж байна.

5.6. Өөрийн урын сангийн шилдэг бүтээлээр хөдөө орон нутаг, алслагдсан дүүргийн иргэдэд жил бүр тогтмол үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэгжилт: 2023 оны 02 дугаар сарын 8-наас 15-ны өдрүүдэд Нийслэлийн 9 дүүргийн ахмадуудад зориулсан ардын урлагийн шилдэг номеруудаас бүрдсэн бүрэн хэмжээний “Colors of Mongolia” тоглолтууд амжилттай тоглосон. Нийт 9 дүүрэгт тоглохоос 7 дүүргийн 3500 гаруй Ахмадуудад, алслагдсан дүүргүүдээс Багахангай, Багануур, Налайх

дүүргийн иргэдэд уран бүтээлийн дээжээ өргөн барьсан ба ирэх 2024 онд хөдөө орон нутаг болон алслагдсан дүүргүүдэд түлхүү аялан тоглолт хийхээр төлөвлөж байна.

Мөн, Хавдар судлалын үндэсний төвтэй хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг бөгөөд энэ 5-р сард 5 удаа хот, хөдөөгийн эмчлүүлэгчдэд зориулж, "Хөгжмөөр эмчилэхүй" тоглолтыг хийн ойролцоогоор 300 гаруй хүнд үйлчилсэн байна.



5.7. Нийслэлийн иргэдэд урлаг соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, түүнийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

Хэрэгжилт: "Улаанбаатар театр" ОНӨТҮГ-ын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, нийслэлийн онцлогийг тусгасан тайзны шинэ шинэ уран бүтээл, урлаг уран. сайхны соёлыг чанарын өндөр түвшинд гаргахыг зорин Стратегийн 5 зорилго, 20 зорилт дэвшүүлэн ажиллахаар төлөвлөсөн. Тус стратегийн төлөвлөгөөг батлуулахаар хяналтын хуудас зурагдаж дууссан бөгөөд одоогоор Нийслэлийн Засаг даргаар батлуулахаар ажиллаж байна.

"Дэлхийн мод" хүүхдэд зориулсан синтез бүтээлийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гарган, Нийслэлийн Засаг даргаар 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр батлуулж, тоглолтын бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд Улаанбаатар театр уран бүтээлийн 4 том төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. "Дэлхийн мод" синтез жүжиг амжилттай тоглогдсон бөгөөд дараагийн Үндэсний хэмжээний "Хар-Хорин" хөгжимт жүжгийн бэлтгэл ажил болох төлөвлөгөө, тайзны зураг, эскиз, зохиол дээр 5 судлаач, зохиолчдоос бүрдсэн төслийн баг ажиллаж байна.

Мөн Соёл, урлагийн байгууллагын эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилтын хүрээнд судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

5.8. Соёл урлагийн хөгжлийг тодорхойлох үндсэн болон хавсарга үзүүлэлтүүдээр статистикийн тоо, баримт, тайлан мэдээг нэгтгэн боловсруулалт хийж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулж байх.

Хэрэгжилт: Соёл урлагийн хөгжлийг тодорхойлох үндсэн болон хавсарга үзүүлэлтүүдээр статистикийн тоо, баримт, тайлан мэдээг нэгтгэн Нийслэлийн Соёл урлагийн газарт 2022 оны жилийн эцсийн, 2023 оны хагас жилийн болон 3,4-р улирлын тоон мэдээг маягтын дагуу гаргаж, тайлагнасан. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газарт нэгтгэгддэг бусад тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

5.9.Соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүмүүсийг төр, засгийн болон нийслэлийн шагналаар шагнуулах талаар хүсэлт, тодорхойлолт гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

Хэрэгжилт: Ажил мэргэжилдээ амжилт гаргаж, мэргэжлийн ур чадвараараа хамт олноо манлайлж ажилласан 12 албан хаагчийн соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг үнэлж, 12 албан хаагчийг төр засгийн одон медалиар шагнуулахаар тодорхойлсноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн цолоор 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 3, Соёлын Яамны Жуух бичигээр -1, Соёлын тэргүүний ажилтан цол

| № | Нэр | Албан тушаал | Шагналын төрөл |
|----------------------------------|---------------|------------------------|---|
| Монгол Улсын Гавьяат цол: | | | |
| 1 | Р.Мөнхсайхан | Уран сайхны удирдагч | Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн |
| 2 | П.Урнаа | Ерөнхий найруулагч | Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн |
| Төрийн одон медаль: | | | |
| 3 | Ц.Баярсайхан | Туслах найруулагч | "Алтан гадас" одон |
| 4 | С.Эрдэнэцэцэг | Ерөнхий нягтлан бодогч | "Алтан гадас" одон |
| 5 | Л.Одгэрэл | Хүний нөөцийн менежер | "Алтан гадас" одон |
| 6 | С.Ширчмаа | Маркетингийн менежер | "Хөдөлмөрийн гавьяаны Улаан туг" одон |
| Салбарын шагнал: | | | |
| 7 | Э.Мөнх-Алдар | Бүжигчин | "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдэг |
| 8 | Б.Оюунгэрэл | Гэрэлтүүлэгч | Соёлын Яамны "Жуух бичиг" |

тэмдгээр 1 албан хаагч шагнуулаад байна.



ЗУРГАДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ -6:

6.1 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах

Хэрэгжилт: Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг 06 дугаар сарын 04-ны өдрийн “Дэлхийн мод” тоглолтын 133 үйлчлүүлэгчээс, 12 дугаар сарын 17-ны өдөр “Зөрүүд Гринч” хүүхдэд зориулсан тоглолтын 42 үзэгчээс нийт 175 үйлчлүүлэгчээс судалгааг авч дүнг нэгтгэж доорх дүгнэлтийг гаргасан.

Тус судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь 16-42 насны хүмүүс байснаас гадна 77.3% нь эмэгтэйчүүд байсан. Манай байгууллагын орчин нөхцөл хэрэглэгчийн хүсэл сонирхолд нийцсэн таатай байдаг боловч театрын гол уран бүтээл болох синтез мюзиклыг үзэж сонирхох үзэгчдийн хандлага бага байгаа нь шинээр хөгжиж байгаа урлагийн төрөл болох мюзиклын талаарх сурталчилгааг мэдээллийн идэвхитэй сувгийг ашиглан, хүмүүст хүргэх таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Уран бүтээлийн чанарт судалгаанд оролцогсдын 93 хувь нь сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн бол, театрын тав тухтай байдалд 77,1 хувь нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байлаа.

Хэрэглэгчдийн 80% нь “Улаанбаатар театр”-т тоглогдох аливаа тоглолтуудын талаарх мэдээллийг интернет болон телевизээс авдаг тул идэвхижүүлэлтийг эдгээр сувгуудаар хийвэл илүү үр дүнтэй болох нь харагдаж байна. Тус судалгааны дүнг үндэслэж, 2024 онд театрын дотоод тав тухыг хангахад анхаарлаа хандуулах нь чухал ажил болоод байна. Мөн, театрыг сурталчлах олон талт ажлыг мэдээллийн эрин зуунд зөв шийдлээр зохион байгуулахад анхаарч ажиллахаар төлөвлөлтийг хийв.

6.2 Театрыг олон нийтэд хүртээмжтэй таниулан сурталчлах олон талт ажлуудыг зохион байгуулна.

Хэрэгжилт: Байгууллагын албан ёсны цахим хуудас болон албан ёсны Нийслэлийн Улаанбаатар чуулга, Улаанбаатар театр facebook page-ээр дамжуулан соёлын үйл ажиллагааг тухай бүр мэдээллийг шинэчлэн, байгууллагын соёл урлагийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан. Олон нийтийн оролцоог татаж нөлөөлөх мэдээлэл сурталчилгааны видео контент бүтээх, Хүүхэд залуучууд, старт ап компаниуд хандсан сургалт арга хэмжээ зохион байгуулах, ДЭЛХИЙН МОД, ЗӨРҮҮД ГРИНЧ төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, үндэсний хэмжээний томоохон ХАРХОРУМ төслийг эхлүүлээд байна.

Улаанбаатар театрын шинэ уран бүтээл “Дэлхийн мод” синтез жүжгийн зар сурталчилгааг зургаан долоо хоногийн турш Улаанбаатар театр, Улаанбаатар чуулгын пэйж, Serchmaa пэйжүүдээр /хандалт 311555/ tseg.mn, zow.mn, tsahiur.mn, zarig.mn сайтуудаар /хандалт 23871/, SBN, MNB, HD Mongol /хандалт 135000/, Мобиком, Юнителийн 63636 хэрэглэгч нар луу мэдээлэл цацагдсан байна.



Улаанбаатар театр, Muppet theatre-ын хамтарсан бүтээл "ЗӨРҮҮД ГРИНЧ" зул сарын сахилгагүй драмын жүжгийн зар сурталчилгаа Улаанбаатар театр пэйж болон Фэйсбүүк пэйж, Олон нийтийн социал сувгууд, UBS, Star TV, МҮОНТ-ээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэмэл цаас, богино хэмжээний рийл, стори, контентуудаар дамжуулан УБ театрыг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг хийн шинэ үзэгчдийн тоог нэмэгдүүлсэн.



6.3 Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах

Хэрэгжилт: 2023 оны хагас жилийн байдлаар төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил одоогоор манай байгууллагад хийгдээгүй байна. Тухайн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг театрын цахим хуудсанд төсвийн мөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлагнах шинэ цонх нээж, байршуулахад бэлэн болгосон.

6.4 “Цахим улаанбаатар” төсөл, “digital first” аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах.

Хэрэгжилт: Театрын тасалбар борлуулалтыг тасалбар борлуулах үйлчилгээ хийдэг www.ticket.mn, www.shopyy.mn, www.ubtheatre.mn, 3 байгууллагатай хамтран, зохион байгуулж ажиллаж хэвшсэн. Мөн байгууллагатай холбогдох хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж Call Center үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. Театрын пейж хуудсанд Chatbot нээж ажиллагаанд оруулаад байна. Цаашид бид, мэдээллийн технологийн шинэ ололт бүхий AR системийг хэрэгжүүлэхээр судалгааны ажил хийгдэж байна. Үүний үр дүнд, хэрэглэгчид, үйлчлүүлэгчид Улаанбаатар театрын бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг хүлээн авахад улам дөт зам нээгдсэн байна.

6.5 Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдлийг бууруулах.

Хэрэгжилт: Тус театр нь мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд иргэдэд урлагийн тоглолт болон тайзны түрээсийн үйлчилгээ үзүүлж ажилладаг. Тус үйлчилгээг иргэдэд хүргэхийн тулд цахим хуудас ашиглан мэдээллээ түгээж, холбоо тогтоох, захиалга авах, гэрээ хийх, төлбөр төлөх зэрэг процессыг цахим хэлбэрт оруулсан. Мөн тасалбар борлуулалтыг ticket.mn, shopyy.mn сайттай хамтран ажиллаж байна.

6.6.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Хэрэгжилт: Улаанбаатар театр нь иргэд болон албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэлийг UB ERP систем дэх “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ” цахим программ ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг. Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан иргэдээс ажилд орох хүсэлт, албан хаагчдаас ажлаас түр болон бүр чөлөөлөгдөх хүсэлтүүд, бусад ажлын гүйцэтгэл, сахилга бат, нийгмийн байдлыг шийдвэрлүүлэх хүсэлтүүд ирснээр театрын дарга тухайн өргөдөлтэй танилцан шаардлагатай тохиолдолд захиргааны зөвлөл болон уран сайхны зөвлөл хуралдан шийдвэрлэдэг.

2023 оны жилийн эцсийн байдлаар театрын захиргаанд хандаж, албан хаагчаас 3 буюу бүжигчин Т.Цэндсүрэнгээс гадаадад гэр бүлээрээ ажиллах амьдрах болсон шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, Тайзны машинист Р.Сийлэгмаа өндөр насны тэтгэвэр тогтоолгож, буцалтгүй тусламж авах, Шанз хөгжимчин Б.Гэрэлтуяагаас гэрээт албан хаагчаар ажиллах хүсэлт ирүүлсэн. Мөн иргэнээс 1 өргөдөл буюу иргэн С.Ширчмаа маркетингийн менежерээр ажиллах, нийт 4 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж, өргөдлийн хариуг өгсөн. Өргөдөл шийдвэрлэлттэй холбоотой гомдол, санал гараагүй.

ERP систем дэх өргөдөл гомдлын тайлангаар: 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Өргөдөл, гомдлын хандалтын индекс-0,026, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн индекс -1, өргөдөл, гомдлын чанарын индекс-1, Өргөдөл, гомдлын индекс-0,814 байна.

| Үзүүлэлт | 2022 он | 2023 он | Өсөлт бууралт |
|---------------------------------------|---------|---------|---------------|
| Хүлээн авсан өргөдлийн тоо | 22 | 3 | -18 |
| Өргөдөл гомдлын хандалтын индекс | 0,026 | 0,026 | - |
| Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн индекс | 1 | 0,938 | -0,062 |
| Өргөдөл гомдлын чанарын индекс | 1 | 0,999 | -0,001 |
| Өргөдөл гомдлын хугацааны индекс | 0,814 | 0,724 | -0,09 |

ДОЛДУГААР ХЭСЭГ. БАЙГУУЛЛАГЫН БУСАД АЖИЛ:

Уран бүтээлийн ажлууд: Улаанбаатар театрын “ДЭЛХИЙН МОД” синтез мюзикл жүжиг Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх “БӨМБӨРЦӨГ ТЕАТР”-т 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нээлтээ хийн, 2023 оны 06 дугаар сарын 04-ний өдрийг дуустал тайзнаа 10 удаа амжилттай тоглож, нийт 3000 гаруй үзэгчдийн хүртээл болсон ба зорилтот бүлгийн 1200 орчим хүүхдүүдэд үнэ төлбөргүй үйлчиллээ.

Улаанбаатар театрын тайз анги болон уран бүтээлчид, циркийн жүжигчид, маркетингийн баг оролцсон нийт 130-аад хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.



Улаанбаатар театр, Muppet theatre-ын хамтын бүтээл Доктор Сьюзийн "Гринч зул сарыг хулгайлсан нь" дэлхийн шилдэг зохиолоос сэдэвлэсэн "ЗӨРҮҮД ГРИНЧ" зул сарын сахилгагүй драмын жүжгийг 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар театрын тайзнаа нээлтээ хийн 12 удаагийн тоглолтоор нийт 4000 орчим үзэгч, хүүхэд багачууддаа толилуулсан байна.

Энэхүү жүжигт Улаанбаатар театрын Бүжгийн багш Д.Баярт бүжиг дэглээч, бүжигчнээр, Х.Алтангэрэл Хөгжмийн зохиолчоор, Л.Баянмөнх Тайз урлаачаар, Бүжигчин Б.Цэвэлсүрэн, Б.Норовбанзад, О.Ганзаяа, Ч.Мэндсайхан, З.Энхжаргал, Г.Аззаяа нар хотын бүжигчнээр тус тус тоглосон.



2023 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд БНТУ тунхагласны 100 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Улаанбаатар театр, Монгол Улсад суугаа Турк Улсын Элчин Сайдын Яамтай хамтран "Турк-Монголын Уламжлалт Ардын хөгжмийн соёлын солилцоо" тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Тус тоглолтод Турк ардын хөгжимчдийн төлөөлөл, авьяаслаг уран бүтээлчид болох Салих Гүндогду, Синан Аялдыз нар Туркийн үндэсний Баглама хөгжмийг үзэгч олонд танилцуулахын зэрэгцээ Улаанбаатар театрын "Хангарди" үндэсний хөгжмийн найралтай хамтран /Монгол ардын уламжлалт хөгжмийн зэмсгүүдтэй хослуулан/ уран бүтээлийн дээжсээсээ толилууллаа.

- 1.2023.01.13. Туушин. НЗДТГ "Аймгуудын ЗД нар"
- 2.2023.01.13. Үндэсний түүхийн музей: УБТ "Үзэсгэлэнгийн нээлт"
- 3.2023.01.27. Налайх С.О. Ш/сайд
- 4.2023.01.27. Шинэ 100 айл төв. НЖДҮГ "Амар байна уу" үзэсгэлэн нээлт
- 5.2023.01.31. Шинэ 100 айл төв: НЖДҮГ "Амар байна уу" үзэсгэлэн хаалт
- 6.2023.02.08. СТӨ. НЗДТГ СХД Ахмадууд
- 7.2023.02.09. СТӨ. НЗДТГ ЧД Ахмадууд
- 8.2023.02.10. СТӨ. НЗДТГ ХУД Ахмадууд
- 9.2023.02.11. Багануур НЗДТГ Ахмадууд
- 10.2023.02.11. Налайх НЗДТГ Ахмадууд
- 11.2023.02.11. Багахангай НЗДТГ Ахмадууд
- 12.2023.02.12. УБТ УСУГ Ахмадууд
- 13.2023.02.12. Скай ресорт. НАЖГ "Өвлийн наадам"
- 14.2023.02.14. Новотел: НЗДТГ, НИТХ Ахмадууд
- 15.2023.02.15. СТӨ: НЗДТГ БЗД Ахмадууд
- 16.2023.02.15. СБ талбай: НЗДТГ
- 17.2023.02.24. УСУГ: УБТ
- 18.2023.03.04. УИД: НЗД-ын орлогч Төмөртөмөө
- 19.2023.03.07. Бишрэлт: НЗДТГ, ТАЗ "Аймгуудын дарга нарт"
- 20.2023.03.08. СТӨ: НЗДТГ "Их хотын бүсгүйчүүд"
- 21.2023.03.08. Их тэнгэр: ЕТГ
- 22.2023.03.15. ХСҮТ: УБТ өдөрлөг
- 23.2023.03.15. Их тэнгэр: ЕТГ
- 24.2023.03.17. Их тэнгэр: ЕТГ
- 25.2023.03.17. СТӨ: НЗДТГ-ЦШ Цэргийн баярын концерт
- 26.2023.03.18. Их тэнгэр: ЕТГ
- 27.2023.03.30. Өмнөговь Цогтцэций: УБТ "Нутаг усны эгшиг" хөгжимчин А.Мөнгөн тоглолт
- 28.2023.03.31. Өмнөговь Даланзадгад: УБТ "Нутаг усны эгшиг" тоглолт
- 29.2023.04.04. Корпорейт: УБТ Мандал даатгал
- 30.2023.04.05. Блу Мон: НЗДТГ-НАЖГ Унгарын соёлын өдөр
- 31.2023.04.05. Их тэнгэр: ЕТГ
- 32.2023.04.07. Их Тэнгэр: ЕТГ /2 удаа/
- 33.2023.04.07. Баянгол ресторан: НЗДТГ-ХХГазар
- 34.2023.04.11. Их тэнгэр: ЕТГ
- 35.2023.05.01. Туушин: Их тэнгэр: ЕТГ
- 36.2023.05.05. SBN TV УБТ-ын зураг авалт, бичлэг
- 37.2023.05.10. ХСҮТ: УБ театр гэрээт ажил "Хөгжмөөр эмчилэхүй"
- 38.2023.05.10. Irish: НИТХ Баярчимэг
- 39.2023.05.12. Их тэнгэр: ЕТГ
- 40.2023.05.16. Хангарьд 16д: НЗД-н орлогч З.Төмөртөмөө Солонгос зочдод
- 42.2023.05.16. Хэнтий: УБТ н.Шархүүхэний нэрэмжит уртын дуу дуулаачдын олон улсын уралдаан
- 43.2023.05.18. Чингисийн хүрээ: НЗДТГ-НАЖГ
- 44.2023.05.19. Мишээл экспо: НЗДТГ-НАЖГ "ITM-2023" үзэсгэлэн яармаг нээлт
- 45.2023.05.20. УБТ: "Дэлхийн мод" жүжгийн дуу бичлэг: дуучид.
- 46.2023.05.22. Их тэнгэр: ЕТГ
- 47.2023.05.22. Хангарьд 16д: НЗДТГ
- 48.2023.05.24. ХСҮТ: УБ театр гэрээт ажил "Хөгжмөөр эмчилэхүй"
- 49.2023.05.24. М.Дугаржавын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 50.2023.05.28. Бөмбөрцөг театр: УБТ "Дэлхийн мод" жүжгийн нээлт
- 51.2023.05.30. ГХЯ: Киргизийн зочдод
- 52.2023.05.30. Энканто 2д: НЗД-ын орлогч З.Төмөртөмөө
- 53.2023.05.31. ХСҮТ: УБТ гэрээт ажил "Хөгжмөөр эмчилэхүй"
- 54.2023.06.05. Инноваци: НЗДТГ Хүний нөөц Хурлын нээлт

- 55.2023.06.10. СБ талай: НЗДТГ-НАЖГ "Талын салхи" нээлт
- 56.2023.06.10. Блу скай: НИТХ
- 57.2023.06.13. МХО: НЗДТГ-ЦШ Германы зочдод
- 58.2023.06.16. Хүүхдийн парк: НЗДТГ "3x3" О/У-ын сагс. нээлт
- 59.2023.06.17. СБ талбай: НЗДТГ-НСУГ Азийн ардын урлагийн наадам
- 60.2023.06.29. Их тэнгэр: ЕТГ-ГХЯ Гадаад яамны эмэгтэй сайд нар
- 61.2023.06.29. Дамчаагийн нэрэмжит уртын дуу дуулаачдын Улсын уралдаан УБТ
- 62.2023.07.01. СЯ Наадмын бэлтгэл
- 63.2023.07.02. Их театр: СЯ Наадмын бэлтгэл
- 64.2023.07.03. Их театр: СЯ Наадмын бэлтгэл
- 65.2023.07.04. Их театр: СЯ Наадмын бэлтгэл
- 66.2023.07.05. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 67.2023.07.06. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 68.2023.07.07. МҮОНТВ: ТВ студийн нээлт УБТ
- 69.2023.07.07. ХУБ төв НЗДТГ "Номын нээлт"
- 70.2023.07.07. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 71.2023.07.08. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 72.2023.07.09. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 73.2023.07.09. СБ талбай: НЗДТГ-НАЖГ "Дээлтэй Монгол" наадам
- 74.2023.07.10. Төв цэнгэлдэх хүрээлэн: СЯ Наадмын бэлтгэл
- 75.2023.07.10. Хүй 7: НЗДТГ ХУД
- 76.2023.07.10. Хүй 7: НЗДТГ БЗД
- 77.2023.07.11. СЯ Наадмын нээлт
- 78.2023.07.11. Хүй 7: НЗДТГ СХД
- 79.2023.07.11. Хүй 7: НЗДТГ ЧД
- 80.2023.07.11. Туушин: НЗДТГ
- 81.2023.07.11. Зайсан: НЗД гадаадын зочдод
- 82.2023.07.12. Хүй 7: НЗДТГ БГД
- 83.2023.07.12. Хүй 7: НЗДТГ СБД
- 84.2023.07.12. Хүй 7: НИТХ Энхтуяа
- 85.2023.07.13. Хүй 7: НЗДТГ ЭСЯ-дууд
- 86.2023.07.13. Хүй 7: НИТХ зочдод
- 87.2023.07.20. Тэрэлж: НИТХ
- 88.2023.07.24. Аварга тосон: НМАН
- 89.2023.07.27. Архангай: 100 жилийн ойн нээлтэнд УБТ-ын мэндчилгээ
- 90.2023.08.02. Аварга тосон: НМАН
- 91.2023.08.05. Хүй 7: НЗДТГ Даншиг
- 92.2023.08.05. Хүй 7: НЗДТГ Даншиг Бөмбөрцөг театрт УБ театрын тоглолт
- 93.2023.08.05. Аварга тосон: НМАН
- 94.2023.08.14. Irish НИТХ Тяньжин хотын зочдод
- 95.2023.08.14. Эко тауэр: НИТХ Ж.Батбаясгалан
- 96.2023.08.15. Централ парк: НЗД орлогч Ж.Сандагсүрэн
- 97.2023.08.17. "Отглоё" кэмп: НЗД орлогч Ж.Сандагсүрэн JCI
- 98.2023.08.17. Аураг төв: УБТ SB production Хурлын зочдод
- 99.2023.08.18. Налайх: СЯ "Нүүдэлчин" наадмын нээлт
- 100.2023.08.18. СБ талбай: НАЖГ О.У-ын хоолны наадам
- 101.2023.08.19. СБ талбай: НАЖГ О.У-ын хоолны наадам
- 102.2023.08.20. СБ талбай: НАЖГ О.У-ын хоолны наадам
- 103.2023.08.23. Чингисийн хүрээ: НАЖГ "О/У-ын оюутан солилцоо"
- 104.2023.08.25. Налайх Хонхор: НАЖГ "Явган алхалтын нээлт"
- 105.2023.08.26. Скай ресорт: УБТ захиалгат ажил
- 106.2023.08.26. Аварга тосон НМАН
- 107.2023.08.27. Тэрэлж UB 2: НАЖГ "Явган алхалт хаалт"
- 108.2023.08.28. Скай ресорт: УБТ захиалгат ажил
- 109.2023.08.29. Аварга тосон: НМАН
- 110.2023.08.30. Төв аймаг: НИТХ Мөнхцэцэг "Ахмадуудад"
- 111.2023.09.01. Их Тэнгэр: ЕТГ

- 112.2023.09.02. Аварга тосон: НМАН
- 113.2023.09.02. Чингисийн хүрээ: НАЖГ "Морьт харваа"
- 114.2023.09.02-12 Хөх хот: СЯ, ХХААЯ "Үзэсгэлэн яармаг"
- 115.2023.09.05. Хөх хот: СЯ, ХААЯ 3 хотын хамтарсан тоглолт
- 116.2023.09.06. Хөх хот: СЯ "Үзэсгэлэнгийн нээлт", 2 тоглолт
- 117.2023.09.07. Хөх хот: СЯ "Үзэсгэлэн яармаг" 2 тоглолт
- 118.2023.09.08. Хөх хот: СЯ "Үзэсгэлэн яармаг" 2 тоглолт
- 119.2023.09.09. Хөх хот: СЯ "Үзэсгэлэн яармаг" 3 тоглолт
- 120.2023.09.08. Хүй 7: НМАН
- 121.2023.09.09. Хүй 7: НМАН
- 122.2023.09.09. Аварга тосон: НМАН
- 123.2023.09.09. Туушин 25д: НИТХ Ж.Батбаясгалан:
- 124.2023.09.10. Хүй 7: НМАН
- 125.2023.09.12. Төв шуудангийн урд өндөрт: НИТХ
- 126.2023.09.15. Аварга тосон: НМАН
- 127.2023.09.17. НЗДТГ Өвөрхангай Бүрд Ширээт цагаан нуур
- 128.2023.09.18. Скай ресорт: НИТХ Баярчимэг
- 129.2023.09.20. Эмээлт: НИТХ Эко паркийн нээлт
- 130.2023.09.21. Төв цэнгэлдэх хүрээлэн: НЗДТГ "Намрын ногоон өдрүүд" нээлт
- 131.2023.09.23. Аварга тосон: НМАН Захиалгат ажил
- 132.2023.09.23. СБ талбай: НЗДТГ-НЭМГ "Машингүй өдөр"
- 133.2023.09.27. Маршал харш: НЗДТГ-НОБГ
- 134.2023.09.28. СБ талбай: Ш/сайд Стандарт хэмжил зүй
- 135.2023.09.28. Мишээл экспо: НЗДТГ-Инноваци
- 136.2023.09.28. УБТ: Солонгосын хөгжимчидтэй Хамтарсан тоглолт
- 137.2023.09.29. Төрийн ордон: Ш/сайд "Стандарт хэмжил зүйн газар-100 жил"
- 138.2023.09.29. УБТ: 805-р ангийн ажил
- 139.2023.09.29. Новотел: НИТХ-НЗДТГ Ахмадуудад
- 140.2023.09.29. Хангарьд 16д: НИТХ Ахмадууд
- 141.2023.09.29. СТӨ: НЗДТГ-Нахмадын хороо
- 142.2023.09.29. МҮХАҮТ: НЗДТГ-Инноваци "Улаанбаатар түншлэл-2023"
- 143.2023.10.01. Төрийн ордон: Хөдөлмөрийн яам Ганхүү Хурлын нээлт
- 144.2023.10.02. УБТ: ОСНААҮГ-ын захиалгат ажил
- 145.2023.10.03. Налайх: НИТХ Налайхын ЗД Ахмадуудад
- 146.2023.10.06. Зайсан Оргил: УБТ МХО-ны багш нарт
- 147.2023.10.06. Чингис хааны музей: УБТ Эрдэм шинжилгээний хурлын нээлт
- 148.2023.10.13. Чингис з/б 1д: ННҮГ
- 149.2023.10.15. Д.Данзанравжаагийн нэрэмжит "Үлэмжийн чанар" О/У-ын уралдаан
- 150.2023.10.17. Их тэнгэр лонж: НЗД-ын орлогч З.Төмөртөмөө
- 151.2023.10.18. УБ ресторан: 1-р эмнэлгийн Төрийн соёрхолт 5 эмч УБТ
- 152.2023.10.18. УБТ: Турк улсын 2 хөгжимчин "Мастер класс"
- 153.2023.10.19. УБТ: Туркийн хөгжимчидтэй "Хамтарсан тоглолт"
- 154.2023.10.20. УБТ: НЗДТГ-Халамжийн газар
- 155.2023.10.20. УБТ: Туркийн хөгжимчидтэй "Хамтарсан тоглолт"
- 156.2023.10.22. УБТ: JCI "Урлагийн наадмын нээлт" НЗДТГ
- 157.2023.10.24. УБ ресторан: НЗДТГ "Фредрих сан-30 жил"
- 158.2023.10.27. Туркийн ЭСЯ: УБТ "Турк улсын 100 жил"
- 159.2023.10.27. Блу скай: НЗДТГ ХЗЯ "Аймгуудын хуулийн хэлтсийн дарга нар"
- 160.2023.10.28. НОБГ: "Шагнал гардуулалт"
- 161.2023.10.28. Централ тауэр 17д: НЗД төлөөлөгчидтэй уулзалт
- 162.2023.10.29. Мэлхийт хөшөө: НЗДТГ Нийслэлийн 384 жил
- 163.2023.10.29. Новотел: НЗДТГ Үе үеийн ЗД нарт
- 164.2023.10.29. СТӨ: НЗДТГ Нийслэлийн 384 жилийн ойн Хүндэтгэлийн тоглолт
- 165.2023.10.29. СБ талбай: НАЖГ
- 166.2023.10.30. Блу скай: ЗАА Зөвлөгөөний нээлт
- 167.2023.10.31. ГХЯ: ХНХЯ гадаадын зочдод /Чех/
- 168.2023.10.31. УБТ: УБТ "Гэмт урьдчилан сэргийлье" сургалт

- 169.2023.11.01. Их тэнгэр Хатантуул: ХНХЯ Чехийн зочдод
- 170.2023.11.03. Ш.Даваахүүгийн нэрэмжит Ардын богино дуу дуулаачдын Олон улсын уралдаан УБТ
- 171.2023.11.06. Амар ресторан: УБТ Гэрэлмаа захиалгат ажил
- 172.2023.11.07. МҮХАҮТ: Н/Стандарт хэмжил зүйн газар
- 173.2023.11.08. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 174.2023.11.09. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 175.2023.11.10. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 176.2023.11.11. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 177.2023.11.12. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 178.2023.11.13. Б.Шаравын нэрэмжит Олон улсын уралдаан УБТ
- 179.2023.11.13. Их тэнгэр Хатантуул: УБТ АШУИС ой
- 180.2023.11.14. МБӨ: ЕТГ Их хааны өдөр, бөхийн нээлт:
- 181.2023.11.18. Амбросиа ресторан: УБТ Циркийн талархлын ажиллагаа
- 182.2023.11.20. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 183.2023.11.21. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 184.2023.11.22. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 185.2023.11.23. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 186.2023.11.24. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 187.2023.11.27. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 188.2023.11.28. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 189.2023.11.29. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 190.2023.11.30. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 191.2023.12.01. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 192.2023.12.02. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 193.2023.12.03. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 194.2023.12.03. Хуримын ордон: НХНХГазар Хөгжлийн бэрхшээлтэй 9 иргэдийн хурим
- 195.2023.12.04. УБТ: Дуучдын сонгон шалгаруулалт
- 196.2023.12.04. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 197.2023.12.05. УБТ: Хөгжимчдийн сонгон шалгаруулалт
- 198.2023.12.05. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 199.2023.12.06. УБТ: Бүжигчид, мюзиклын жүжигчдийн сонгон шалгаруулалт
- 200.2023.12.06. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 201.2023.12.07. УБТ: ОСНААҮГ захиалгат ажил
- 202.2023.12.07. Их наяд: НТСан "Санхүүчдийн өдөр"
- 203.2023.12.07. Цагаан ордон: УБТ Циркчдийн нэгдсэн баяр
- 204.2023.12.07. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 205.2023.12.08. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн сургуулилт
- 206.2023.12.09. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн Нээлт 3 удаа
- 207.2023.12.10. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн Нээлт 3 удаа
- 208.2023.12.15. Удирдлагын академи: УБТ /захиалгат ажил/
- 209.2023.12.16. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн тоглолт
- 210.2023.12.17. УБТ: "Зөрүүд Гринч" хүүхдийн жүжгийн тоглолт
- 211.2023.12.11. Перфект: УБТ-ын гоцлол дуучин О.Анхчимэгийн CD-ний баяр
- 212.2023.12.13. Айриш: НИТХ захиалгат ажил
- 213.2023.12.14. Гранд UB: УБТ Удирдлагын академи
- 214.2023.12.16. Хүнрү: ННийтийн тээвэр
- 215.2023.12.19. Блу скай: УБТ ЦДБЭЧ захиалгат ажил
- 216.2023.12.24. СБ талбай: НЗДТГ-НСУГ "Мөнгөн шөнө" цуврал ажил Сонгодог үдэш
- 217.2023.12.25. СБ талбай: НЗДТГ-НСУГ "Мөнгөн шөнө" цуврал ажил Этник үдэш
- 2023.12.28. Нью Гарден: Нийслэлийн архив

2023 онд Улаанбаатар театрын Нийт уран бүтээлчид тоглолтонд оролцсон тоон мэдээлэл:

| | | |
|---|------|--------|
| Нийт ажлын тоо: | | 218 |
| Нийт оролцсон уран бүтээлчид /давхардсан тоогоор/ | | 3052 |
| Нийт үзэгчдийн тоо /давхардсан тоогоор/ | | 50.451 |
| Задаргаа: | | |
| Өөрийн байранд тоглосон тоглолт | 37 | |
| Оролцсон уран бүтээлчид: | 770 | |
| Үзэгчдийн тоо: | 2960 | |

| | | |
|----------------------------------|--|----|
| Үүнээс: | | |
| Ерөнхийлөгчийн тамгын газар | | 13 |
| Шадар сайд | | 3 |
| ГХЯ | | 2 |
| Сангийн Яам | | 12 |
| Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам | | 3 |
| НМАН | | 12 |
| УБТ | | 79 |
| НИТХ | | 17 |
| НЗДТГ, харъяа агентлагууд | | 77 |






2023 оны жилийн эцсийн байдлаар захиалгат болон төлөвлөгөөт тоглолтоор 218 ажилд оролцож, 56.491.990 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлж ажилласан.

Тайзны түрээсийн үйл ажиллагаа, орлого төвлөрүүлэлт: Улаанбаатар театрын үзэгчдийн их танхимд өөрийн төлөвлөгөөт тоглолтуудаас гадна Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нийслэлийн харьяа байгууллагуудын тайзнаа зохион байгуулах ажлууд болон төлбөртэй захиалгат ажлуудыг авч захиалгын дагуу зохион байгуулж, төлбөрт ажлын төлбөрийг нийслэлийн төсөвт төвлөрүүлдэг. 2023 оны жилийн эцсийн байдлаар тайзнаа 82 ажил + 52 хоногийн Хөгжлийн банкны шүүх хурлын үйл ажиллагааг зохион байгуулж, 107.550.000 төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлж ажилласан. Тайзны захиалгат ажлыг театрын үндсэн үйл ажиллагаа болох уран бүтээлчдийн бэлтгэл сургуулилт, нийллэгийн цагаас гадна чөлөөтэй байгаа цагууд дээр захиалгыг хүлээн авч зохицуулж ажилласан.

Урлагийн тоглолт, тайзны захиалгат ажил нийлээд нийт 164,041,990 төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэв.

Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал: Театрын сошиал мэдээллийн суваг болох Улаанбаатар театр, Нийслэлийн Улаанбаатар чуулга фэйсбүүк хуудас, Youtube channel, Инстаграмм хуудсуудаар дамжуулан театрын уран бүтээл, уран бүтээлчдийн тухай өдөр тутмын мэдээ мэдээллийг шинэчлэх, онлайн хэлбэрээр уран бүтээлээ үзэгчдэд хүргэх болон хэрэглэгчдийн санал, асуултуудад шуурхай хариулах зэрэг ажлыг гүйцэтгэхэд анхаарлаа хандуулж, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод тайлагнан ажиллаж байна.

Улаанбаатар театр албан ёсны веб хуудас болон Mongol HD, MYONPTB, SBN, NTV, C1, UBS, ETV, Малчин ТВ, Star ТВ зэрэг телевизүүдтэй хамтын ажиллагааны гэрээ хийж, театрын урын сан дахь уран бүтээлийг олон нийтэд таниулан сурталчлах, уран бүтээлчдийг телевизийн нэвтрүүлэгт урьж оролцуулах зэргээр таниулга, сурталчилгааг тогтмол хийж ажилласан.



Төсөв, санхүүгийн ил тод байдал: Нийтийн мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаал, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу сар бүр байгууллагын орлого, зарлагын гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, улирал бүр санхүүгийн тайланг гаргаж НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж, НДШ, татварын тайланг шивж илгээн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллүүдээ тогтмол шинэчилж, архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтэрч татан авч үзэх, хэвлэх боломжоор хангаж ажиллаа. НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд мэдээ, санхүүгийн тайланг хүргүүлэн баталгаажуулан байгууллагын цахим хуудсанд Төсөв, санхүүгийн ил тод байдал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2022 оны жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг

хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансанд 2023 онд 125 мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэйгээр байршуулж ажилласан.

Өмч хамгаалал: Энэ жил манай театр нилээд том уран бүтээл амжилттай зохион байгуулж урын сандаа нилээдгүй их зохиол бүтээлтэй арвин жил боллоо. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/291 дүгээр захирамжаар Засгийн газраас 2023-2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлан таниулах соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх зорилгоор, Нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд баригдсан Бөмбөрцөг театрт тоглогдсон "Дэлхийн мод" синтез мюзикл жүжгийн тайз, уран бүтээлчдийн хувцас зэргийг Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын Даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2/485 дугаар зөвшөөрөл, Театрын Даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/11 тоот тушаалын дагуу "Шаки Эделвайс" ХХК-аас жүжгийн хувцас болох бусад үндсэн хөрөнгө, хувцасны дизайнер Д.Мягмарсүрэнгээс тайзны жижиг хэрэглэл, хувцас бүхий бараа материал "Анх Эрдэнэ Төгс" ХХК-аас жүжигчдийн хувцас солих контейнер сууц, зэргийг Театрын Даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хагас жилийн Эд хөрөнгийн тооллогын А/13 тоот комиссоор цаашид ашиглагдах жилийг тогтоож ажлын хэсэг байгуулсан.

Гоцлол бүжигчин Б.Норовбанзадын бүтээл "Хөх шувуу", бүжигчин Э.Мөнх-Алдарын "Огторгуйн Хангал" зэрэг тус тус бүжгийн хувцсыг Театрын Даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/03 тоот тушаалаар, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 3/534 дүгээр зөвшөөрлөөр "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн хурлаар элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон эд хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож нийт 193 нэр төрлийн 422,186,652.8 (дөрвөн зуун хорин хоёр сая нэг зуун наян зургаан мянга зургаан зуун тавин хоёр төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон бүртгэлд тусгах үнийг тогтоосон. Үндсэн хөрөнгө 3-р улирлын байдлаар: 1,406,025,148,67 төгрөг, Бараа материал 29,606,516 төгрөгний хөрөнгийг тооллоо.

Мөн Улаанбаатар театрын Даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/26 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулан ажиллаж, тооллогоор ашиглалт хамгаалалтанд хяналт тавьж коджуулж, шинээр авсан хөрөнгө, акталсан, хөрөнгүүдийн фото зураг болон бусад холбогдох бичиг баримтуудыг хавсаргасан.

2023 оны Улаанбаатар театрын хяналт-шинжилгээ үнэлгээний чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлын хүрээнд батлуулсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг журмын дагуу гүйцэтгэж ажилласан. Тус театрын бүтэц, орон тооноос хамаарч, Дотоод хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэний албан тушаалыг Хүний нөөцийн менежер түр хугацаагаар хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, театрын даргаар батлуулсан.

Хүний нөөцийн бодлогын ил тод байдал: Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн туухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан ажилласан. Сул орон тооны зарыг цахим сүлжээ болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах гэсэн заалтын дагуу:

- 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын батлагдсан орон тоо 146. Одоо ажиллаж байгаа 69. 2023 онд ажилд орсон 25, ажлаас чөлөөлөгдсөн 14. Үүнээс, өөрийн хүсэлтээр 11, жирэмсний болон хүүхэд асрах чөлөө

авсан 2, цалингүй хувийн чөлөө 1 албан хаагч аваад байна. Мөн ажилд ажилд томилогдсон 25 албан хаагч: үүнээс түр орон тоонд томилсон 4, хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон 1, театрын нөөцөөс ажилд томилсон 12, нээлттэй ажлын байрны зараас 6, театрын захиргааны санаачлагаар 5 хүнийг ажилд томилсон байна.

Нээлттэй ажлын байрны зарыг Нийслэлийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 20-ий өдрийн А/263 дугаар захирамжаар театрын бүтэц орон тоог 146 болгон шинэчлэн баталсантай холбогдуулан нэн шаардлагатай дутагдалтай байгаа ажлын байранд ажилтан шалгаруулж, цалингийн санд багтаан ажилд авсан. Театрын вебсайт, сошиал хуудас, мэдээллийн самбар болон тухайн зарлагдсан албан тушаалтай хамааралтай ажлын зарын группуудээр дамжуулан ажлын байрны зарыг хүргэж ажилласан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэ орон тоогоор ажиллах бэлтгэлийг хангаж уран бүтээлчдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан.

Тус сонгон шалгаруулалтад оролцохоор нийт 77 уран бүтээлч бүртгүүлсэн бөгөөд дуучин 48, хөгжимчин 12, бүжигчин 9, мюзиклын жүжигчин 8 шалгуулав. Эхний шатны шалгаруулалтад тэнцсэн уран бүтээлчийг театрын үндсэн уран бүтээлчидтэй нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 11-13-ний өдрүүдэд аттестатчилалын шалгалт авахаар төлөвлөн, бэлтгэл ажил хангагдаад байна. Ингэснээр, театрын уран бүтээлчдийн бүрэлдэхүүн шинэчлэгдэж, цоо шинэ уран бүтээлээр үзэгч олны сонорыг мялаах юм.


Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх гэсэн заалтын дагуу: Театрын даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар театрын Ёс зүйн зөвлөлийн 5 гишүүнтэй шинэчлэн байгуулж, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан. Шинээр баталсан ёс зүйн дүрмийг www.ubtheatre.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан, дүрэм журмын хавтас нээж албан хаагчдад танилцуулсан.

Тус ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдад ёс зүйн талаар таниулга сурталчилгааг тогтмол хийж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төрийн албанд ажиллах бөгөөд ёс зүйн үнэт зүйл, зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчилон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүйгээр ажиллахад анхаарч ажилласан. 2023 оны 10 дугаар сарын 23,25-ны өдрүүдэд нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, УБ театрын Ёс зүйн дүрэм, УБ театрын дотоод журам, Ёс зүйн хэм хэмжээний талаар 2 удаагийн сургалтыг 89 албан хаагчийг хамруулж ажилласан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан 4 албан хаагчийг Ёс зүйн зөвлөлийн хурлаар авч хэлэлцсэний дагуу театрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. Мөн, хөнгөн зөрчил гаргасан 3 албан хаагчид эхний удаагийн сануулга өгч, дахин ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахыг анхааруулсан.

Мөн, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшлийн 7/4/10 Пүрэв гарагийн вебирнар сургалтанд албан хаагчдаа хамруулж, 2 удаагийн сургалтанд 32 албан хаагчийг хамруулж ажилласан.

Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх заалтын дагуу:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ:



БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЛҮҮД

| Байгууллагын хүний нөөцийн бодлого | Тайлбар |
|---|---|
| <p>Ажилтныг ажилд авах, ажлыг нь танилцуулах, сургах, идэвхжүүлэх, ажлын үр дүнг нь үнэлэх, зааж зөвлөх, тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах бодлого, журам батлан мөрдөж ажиллах</p> | <p>Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Улаанбаатар театр ОНӨТҮГ-ын дүрэм, театрын “ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ зэргийг баримтлан ажилладаг. Мөн байгууллагын даргын тушаалаар батлагдсан ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР зэргийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.</p> |
| <p>Удирдлагын зүгээс шинээр ажилтан авахад оролцох гол оролцооны болон ажилтныг сонгож, шалгаруулж ажилд авах</p> | <p>Мэргэжлийн урлагийн байгууллагын онцлогоос шалтгаалан мэргэжлийн уран бүтээлчдийг шалгаруулж авах шаардлагатай байдаг бөгөөд гарсан сул орон тоон дээр театрын дарга, уран сайхны зөвлөл гол үүрэг гүйцэтгэж оролцдог. Мэдээллийг ил тодоор байршуулдаг, төрийн албан хаагчийн анкетыг бүрдүүлж сонгон шалгаруулалтыг журмын дагуу явуулдаг. Хүний нөөц тогтвор суурьшил сайтай, тухайн жилийн уран бүтээлийн онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд нэмэлт уран бүтээлчдийг түр хугацаагаар ажиллуулдаг.</p> |
| <p>Ажилтны үйл ажиллагааг үнэлэх</p> | <p>Албан хаагчдын үйл ажиллагааг сар, улирал, жилээр тооцон дүгнэж, ажлын үр дүн, мэргэшлийн түвшин, мэргэжлийн ур чадварыг үнэлж дүгнэх, үр дүнгийн шагнал, урамшуулал олгох зохих дүрэм журмын хүрээнд үнэлж дүгнэдэг.</p> |
| <p>Ажилтны ажлын үр дүнг харгалзан урамшуулдаг болон хариуцлага тооцох механизмын үйлчлэлийн талаарх мэдээлэл</p> | <p>Дээрх журмуудын дагуу хариуцлага тооцдог, мөн урамшууллыг олгодог.</p> |

| | |
|---|---|
| <p>Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалтын хийх</p> | <p>Албан хаагчдын хувийн хэргийг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс баталсан Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу хөтөлдөг. Мөн жилд 1 удаа хувийн хэргийн шинэчилсэн баяжилтыг хийж, албан хаагчийн мэдээллийн баяжуулалтыг хийж ажилладаг.</p> |
| <p>Байгууллагын газар хэлтсийн ажил үүргийн хуваарьтай, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт тохирч байгаа эсэх талаарх мэдээлэл</p> | <p>Албан тушаалын тодорхойлолт албан хаагчдын ажил үүргийн хуваарьтай холбогддог бөгөөд Театрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/06 дугаар тушаалаар баталсан Албан тушаалын тодорхойлолтыг мөрдөн ажиллаж байна. Мөн, шинээр нэмэгдсэн орон тоо, албан тушаалд ажлын байрны шинжилгээ хийж албан тушаалын тодорхойлолтыг үйлддэг.</p> |
| <p>Байгууллагын хэрэгцээ шаардлагад үндэслэсэн мэргэжлийн сургалтын хөтөлбөр болон түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл</p> | <p>Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, жил бүрийн сургалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилладаг.</p> |
| <p>Байгууллагын ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллаж байгаа талаарх мэдээлэл</p> | <p>Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн 2022 оноос эхлэн нэлээд ихсэх хандлагатай болж ирсэн. Үүний гол шалтгаан нь Улаанбаатар театр чуулгаас театр болж өргөжиж, бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбоотой. Албан хаагчдын шилжих хөдөлгөөний хувь 21.5%, 2022 онтой харьцуулахад 15.1%-аар буурсан үзүүлэлттэй байна. 3-аас доош жил ажиллаж байгаа албан хаагчийн тоо 23.</p> |
| <p>Ажилтнуудын тогтвор суурьшил, тухайн жилд шинээр нэмэгдсэн, хорогдсон орон тооны талаар</p> | <p>2023 онд ажилд орсон 25, ажлаас чөлөөлөгдсөн 14. Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан 2, цалингүй чөлөө 1 албан хаагч аваад байна</p> |

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх заалтын дагуу:

Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж www.ubtheatre.mn веб сайтаар холбогдох мэдээ мэдээллийг тайлагнаж ажилласан. Театрын даргын тушаал шийдвэрийг веб хуудсанд байршуулахдаа, Хувь хүний нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг нээлттэй мэдээлэхгүй байх чиглэлийн дагуу ажилласан.

Вебсайтад:

- “Албан хаагчийн ёс зүйн дүрэм”
- “Улаанбаатар театрын хөдөлмөрийн дотоод журам”
- Албан тушаалын тодорхойлолтууд,
- “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”
- “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” түүний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт,
- “Сургалтын хөтөлбөр” түүний төлөвлөгөө хэрэгжилтийн тайлан,

- Сул орон тооны тухай мэдээлэл,
- Шинээр ажилд орсон албан хаагчдын талаарх мэдээлэл гэх мэтчилэн байгууллагын хүний нөөцийн удирдлагын талаарх бүхий л мэдээллийг тайлагнаж, ил тод мэдээлэх нөхцөл бүрдүүлэн ажилласан. Мөн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг www.ubtheatre.mn сайт болон дотоод үйл ажиллагаанд албан хаагчдад нээлттэй танилцуулах хавтсанд хийж хадгалж, түүний баяжилтыг тухай бүр хийж хэвшсэн.

Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх заалтын дагуу: Хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаархи үнэн зөв мэдээллийг бэлтгэн, байгууллагын мэдээллийн самбар болон дотоод ажлын UB THEATRE STAFF группээр дамжуулан албан хаагчдад цаг алдалгүй хүргэн ажилласан. Тайлан хугацаанд театрын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цалин хөлсний журам”, “Албан тушаалын тодорхойлолт” зэргийг шинэчлэн баталсны дараа албан хаагчдад зориулсан тус дүрэм журмын талаар сургалтыг зохион байгуулж, театрын веб хуудас болон албан хаагчдыг дотоод группэд байршуулан мэдээллээр хангаж ажилласан.

Архивын ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа: “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” Баримт бичгийн стандарт MNS 5140-1:2021 “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” /ТАХХҮЗ/ “Тамга тэмдэг баталгааны тэмдэг хэрэглэх заавар” холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж Захиргааны албан бичиг боловсруулсан албан хаагчдаас ирсэн, явуулсан, харилцсан бичиг тэдгээрийн хавсралт бүхий баримт бичгүүдийн боловсруулалт стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллаа.

Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам буюу 2015 оны 03 дугаар сарын 06- ны өдрийн А/177 дугаар тоот журам, Монгол улсын засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам” Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/528 тоот “Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын дүрэм” Нийслэлийн засаг даргын 2015 оны 07 сарын 29-ны өдрийн А/633 дугаар захирамж”, Монгол улсын хууль дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 тоот журам буюу “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаж байна.

Нөхөн бүрдүүлэлт, тоо бүртгэл: 2023 оны 01 сарын 15-ны өдөр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 59 хадгаламжийн нэгжээс байнга хадгалах 30, түр хадгалах 26, 70 жил хадгалах 3 хадгаламжийн нэгжийг хүлээн авах хуваарь гарган батлуулсан.

Хуваарийн дагуу Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу

- Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн 01 сарын 25-ны өдөр 21 хадгаламжийн нэгж
- Маркетингийн менежерээс 03 сарын 03-ны өдөр 6 хадгаламжийн нэгж
- Хүний нөөцийн менежерээс 02 сарын 15-ны өдөр 11 хадгаламжийн нэгж
- Санхүүгийн 04 сарын 03-ны өдөр, 24 хадгаламжийн нэгж
- Архивын эрхлэгчийн 02 сарын 10-ны өдөр 11 хадгаламжийн нэгж тус тус хүлээн авав.

Байнга, түр, 70 жилийн баримтыг стандартын дагуу үдэж хавтаслаж бүртгэлжүүлсэн.

Нийслэлийн Архивын газрын даргын 2019 оны А/64 дүгээр тушаалаар “Тусгай төрлийн баримтыг зохион бүрдүүлэх тоо бүртгэл, нөхөн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааны заавар”-ын дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүссэн гэрэл зураг, дүрс бичлэг, цахим баримт, гэрэл зургийн цомог зэргээр нөхөн бүрдүүлэлт хийж ажиллав.

244

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтанд цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжын дагуу 2006-2022 оны захирамжлалын 510, хуудасны тоо 43,580 баримтын тоо 2,067 баримт хавсаргасан цахим хувь болон хавсралтуудын бүрдэл, үг үсгийн алдаанд нягтлан шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж нөхөж хийж 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримтаа “UB ERP” нэгдсэн системийн “Archive edoc” -д <https://arch.ulaanbaatar.mn/> нөхөн бүрдүүлэлт хийж төрийн архивын хэлтэст хүлээлгэн өгч акт авсан.

Байгууллагын архивын тоон тайлангаа Нийслэлийн архивын газарт илгээсэн. Байгууллагын архивт тавигдах шаардлагын дагуу байгууллагын боломжид тулгуурлан шаардлагатай тоног төхөөрөмж болон аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн үйл ажиллагаагаар байгууллагын түүхчилсэн лавлах үйлдэж баяжилт хийлээ. Архив албан хэрэгт тогтмол ашиглаж байгаа компьютер, түүний үйлдлийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагааг хангахын тулд лицензтэй үйлдлийн систем болон вирусын програмыг ашиглаж байна. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт Нийслэлийн архивын газрын мэргэжилтнээр хянуулан байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссоор батлуулсан.

Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын үйл ажиллагаа: Архивт хүлээн авсан баримтыг батлагдсан бүртгэл, тоо ширхэг, стандартын дагуу зөв байрлуулан байнга, түр, 70 жил тусгай төрлөөр төрөлжүүлэн байрлал заагч хийж байрлуулаа. мөн 2006-2022 оны баримтуудад нягтлан шалгалт хийж түр хадгалах хугацаа дууссан баримтууд ялгаж устгах актын бүртгэл үйлдээд байна.

Хадгалалт хамгаалалт: Архивын зориулалтын өрөө тасалгаанд зориулалтын нягтруулсан шүүгээнд сэдэв зүйн заалтын дагуу архивын баримтыг байнга, түр, 70 жилийн дарааллаар нь ангилан өрж байрлуулсан. Мөн тусгай төрлийн баримт болох гэрэл зураг дүрс бичлэг гэрэл зургийн цомог зэргийг нягтруулсан шүүгээнд байрлуулан хадгалж байна.

Хадгаламжийн сангийн өрөөны тавиур шүүгээ хавтасны тоос шороог 7 хоногт 2 удаа соруулж, өрөөний шал цонхны тавцан, тавиур зэргийг халдваргүйжүүлэх бодистой чийгтэй цэвэрлэгээг /2%/ийн формалин/, жилд 2-оос доошгүй удаа ариутгах ажлыг үйлчилгээний ажилтнаар тогтмол хийлгэж байна.

Хадгаламжийн сангийн өрөө чийг дулааны эрс хэлбэлзэлтэй байдаг. Агааржуулалтын системгүй болохоор агаар чийгшүүлэх, хуурайшуулах техник хэрэгсэл ашиглах, халаалт тохируулах, агаар оруулах зэрэг ажлыг өөрийн биеэр биечлэн өдөр тутам арга хэмжээ авч ажилладаг. Агаарын чийгшил 70-80 % хүртэл удаан хугацаагаар хадгалагдах тохиолдолд дээрхи нөхцлийг хэвийн болгох зорилгоор эрчимтэй агааржуулах, салхи оруулах, хуурайшуулах, чийгшил ихдэж буй арга шалтгааныг тогтоож арилгах арга хэмжээг авч ажиллав. Чийг дулааны хэмжээг тогтмол хянаж бүртгэл хөтөлдөг. Архивын өрөөг хөгц, хорхой шавьж, хортон мэрэгчээс хамгаалж хор цацуулж байнгын цэвэр нөхцөлд байлгадаг.

Архивын өрөөний зохион байгуулалт, цэвэрлэгээ үйлчилгээг өдөр тутам хийж байна.



Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт: Тус театрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим баримт бичгийн солилцоо” стандарт /MNS ISO 17933:2008/, 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021/ болон холбогдох эрх зүйн акт, энэхүү журмыг дагаж мөрдөн ажиллаж байна.

Театрын албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.edoc.ulaanbaatar.mn домайн нэр бүхий онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Цахим хэлбэрээр үүссэн баримт бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулж, албан хэрэг хөтлөлтийг архив, бичиг хэргийн эрхлэгч хариуцан ажиллаж байна.


Албан хэрэг хөтлөлт, ирсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн байдал: Тус газар нь албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна. Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.edoc.ub.gov.mn онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна.

Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, судалж шийдвэрлэх, хариу өгөх болон мэдээлэл-лавлагаанд шаардлагатай бүх баримт бичгийг хүлээн авч, бүртгэн үйл ажиллагааг edoc.ulaanbaatar.mn онлайн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Хэрэгжилт-99.40%

2023 оны жилийн эцсийн байдлаар /албан бичгийн индекс -0.4089/ **нийт 233** албан бичиг ирснээс **хариутай-66хариугүй -166** /хугацаандаа хаасан -232, хугацаа хэтэрч хаасан-1, шийдвэрлэлтийн хувь-99.40%/, байна. Нийт явсан бичиг 183 /хариутай бичиг 3, хариугүй бичиг 180 шийдвэрлэлтийн хувь-100% байна. Хариугүй албан бичиг 166

ирснээс 100%-тай хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Баримт бичигт шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Баримт бичигт шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Биеийн тамир, спорт: 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн театрын даргын А/08 дугаар тушаалаар биеийн тамирын хамтлагийг Дотоод ажил, тайлан мэдээ, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэгээр ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй батлан байгуулагдаж, байгууллагын албан хаагчдын дунд биеийн тамир, спорт чийрэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, бие бялдрын боловсрол, соёлыг дээшлүүлэн, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан.



Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын V наадам 2023 оны 10 дугаар сарын 13-аас 15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж Улаанбаатар театрын ажилтан, албан хаагчид "Ажлын байрны дасгал"-ын төрлөөр нийслэлийн хэмжээнд Тэргүүн байр, Улсын хэмжээний уралдаанаас Мөнгөн медаль хүртэж амжилттай оролцлоо.



ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА



Ю.ГЭРЭЛБААТАР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДОТООД АЖИЛ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Л. Цолмон* ЦОЛМОНЧИМЭГ